



Нээлттэй  
Нийгэм  
Форум

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

# ИНФЛЯЦИЙН ЭСРЭГ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

---

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**Бодлогын судлаач:**

Ц.БАТСҮХ  
СЭЗДС–ийн Экономикс,  
эконометриксийн тэнхмийн  
эрхлэгч, доктор (Ph.D)

2008 он

DDC  
339.5  
Б-34



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Хаяг: Жамъян гүний гудамж-5/1,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48,  
Монгол Улс  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Уг судалгаагаар гаргасан дүгнэлт, саналууд нь  
судлаачийн үзэл бодлыг илэрхийлнэ.

© Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл ННФ-ын  
хаягаар хандаж зохих зөвшөөрөл авна уу.

Энэ судалгааны тайланг сонирхсон байгууллага, хувь хүмүүст хямдралтай  
үнээр худалдана.

**ISBN 978-99929-0-559-X**

“ADMON” компанид эхийг бэлтгэж хэвлэв.

## **АГУУЛГА**

### **БҮЛЭГ 1. Судалгааны ажлын арга зүй, үндсэн ойлголт, ухагдахуун**

1.1. Ерөнхий танилцуулга .....	1
1.2. Судалгааны хүрээнд хэрэглэгдэх үндсэн ойлголт, ухагдахуун .....	3
1.3. Бодлогын асуудлын тодорхойлолт .....	5
1.4. Судалгааны асуултууд .....	6
1.5. Судалгааны таамаглал .....	7
1.6. Хувьсагчид .....	7
1.7. Судалгааны объект, түүврийн хүрээ, хэмжээ .....	8
1.8. Судалгааны хүрээнд хийгдсэн ажлууд .....	9
1.9. Судалгааны ажлын арга зүй .....	10
1.10. Мэдээллийн эх үүсвэр .....	10

### **БҮЛЭГ 2. Инфляцийн холбогдолтой онолын болон эмпирик судалгааны тойм**

2.1. Онолын судалгааны тойм .....	11
2.2. Эмпирик судалгааны тойм .....	18
2.3. Монголын инфляцийн нөлөөлөгч хүчин зүйлсийн эмпирик судалгаа .....	26

### **БҮЛЭГ 3. Монголын инфляци улирлаа даган өөрчлөгддөг**

3.1. Хэрэглээний үнийн индексийн бүрэлдэхүүн хэсгийн шинжилгээ .....	29
3.2. Сарын инфляцийн тархалт, хэлбэлзлийн заагийн шинжилгээ .....	31
3.3. Хэрэглээний үнийн индексийн хугацааны цувааны эконометрик шинжилгээ .....	33

**БҮЛЭГ 4. Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжлэхүй**

4.1. Дотоодын нийт бүтээгдэхүүний мөчлөгийн шинжилгээ .....	35
4.2. Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн шинжилгээ .....	39
4.3. Төсвийн байгууллагын ажиллагсдын цалингийн шинжилгээ .....	40
4.4. Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн шинжилгээ .....	41
4.5. Бензиний үнийн шинжилгээ .....	42
4.6. Гадаад худалдааны тэнцэл.....	43
4.7. Хөрш орнуудын инфляц .....	44

**БҮЛЭГ 5. Монголын инфляцийн өсөлтөд мөнгөнийхөөс илүү мөнгөний бус хүчин зүйлс нөлөөлдөг**

5.1. Хэрэглээний үнийн индекс ба бусад үзүүлэлтүүдийн хугацааны цувааны бүрэлдэхүүний хамаарал .....	47
5.2. Үзүүлэлтүүдийн интегретэдийн эрэмбэ.....	48
5.3. Үзүүлэлтүүдийн учир шалтгаан, үр дагаврын холбоо .....	49
5.4. Үзүүлэлтүүдийн статистик хамаарал.....	50
5.5. Хэсгийн Корреляцийн шинжилгээ .....	51

**БҮЛЭГ 6. Шинжилгээний нэгдсэн дүгнэлтүүд .....** 53

**БҮЛЭГ 7. Инфляцийн эсрэг бодлогын хувилбар, зөвлөмж**

7.1. Богино хугацааны бодлого .....	57
7.2. Дунд хугацааны бодлого.....	58
7.3. Урт хугацааны бодлого .....	60

**Хавсралтууд .....** 65

**Ашигласан ном, судалгаа .....** 86

**Товчилсон үгийн жагсаалт**

ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
БДНБ	Бодит дотоодын нийт бүтээгдэхүүн
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс

**Хүснэгт**

Хүснэгт 1.	Хэрэглээний үнийн индекс ба инфляцийн түвшин, 1991-2006 он	3
Хүснэгт 2.	Бодлогын судалгааны хувьсагчид	8
Хүснэгт 3.	Инфляцийн таамаглал	34
Хүснэгт 4.	Нэрлэсэн болон Бодит ДНБ-ий динамик, өсөлтийн хувь	35
Хүснэгт 5.	БДНБ-ий мөчлөг нөлөөллийн динамик	38
Хүснэгт 6.	Төсөвт байгууллагын ажиллагсдын дундаж цалин, түүний динамик	41
Хүснэгт 7.	Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын ХҮИ-ийн корреляцийн матриц	44
Хүснэгт 8.	ХҮИ ба түүнд нөлөөлөгч үзүүлэлтүүдийн корреляц хамаарал	47
Хүснэгт 9.	Үзүүлэлтүүдийн интегретэдийн зэрэг	48
Хүснэгт 10.	Үзүүлэлтүүдийн учир шалтгааны холбоо	49
Хүснэгт 11.	ХҮИ ба тайлбарлагч үзүүлэлтүүдийн хамаарлын зүй тогтол	50
Хүснэгт 12.	Хэсгийн корреляцийн шинжилгээний үр дүн	51
Хүснэгт 13.	Инфляцийн эсрэг бодлогын хувилбар	61

**Зураг**

Зураг 1.	Жилд шилжүүлсэн инфляцийн түвшин, 1996-2007 он	6
Зураг 2.	Хэрэглээний үнийн индекс, 1995-ХИ-31-100%	30
Зураг 3.	ХҮИ-ийн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгүүд	31
Зураг 4.	Сарын инфляцийн динамик	32
Зураг 5.	Сарын инфляцийн тархалтын нягтын функцийн график	32

Зураг 6.	Хэрэглээний үнийн индексийн чиг хандлага	33
Зураг 7.	Бодит ДНБ ба түүний чиг хандлага	36
Зураг 8.	Малын тоо толгой	37
Зураг 9.	Зэсийн үнийн динамик	38
Зураг 10.	М1 мөнгөний динамик, түүний бүрэлдэхүүн хэсгүүд	40
Зураг 11.	Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн динамик	42
Зураг 12.	А93 бензиний үнийн индексийн динамик	42
Зураг 13.	Гадаад худалдааны тэнцэл, 1999-2007	43
Зураг 14.	ОХУ-ын Хэрэглээний үнийн индекс	45
Зураг 15.	БНХАУ-ын Хэрэглээний үнийн индекс	45

### **Хавсралт**

Хавсралт 1.	Инфляцийн төрлүүд	65
Хавсралт 2.	Инфляцийн зарим онолын математик үндэслэл	66
Хавсралт 3.	Хэрэглээний үнийн индексийн прогнозын загварын эконометрик үнэлгээ	69
Хавсралт 4.	Бодит ДНБ-ий чиг хандлагын шинжилгээ	70
Хавсралт 5.	ХҮИ-ийн стационарийн шинжилгээ	71
Хавсралт 6.	М1 мөнгөний стационарийн шинжилгээ	73
Хавсралт 7.	Төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн стационарийн шинжилгээ	76
Хавсралт 8.	А93 бензиний үнийн индексийн стационарийн шинжилгээ	78
Хавсралт 9.	Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн стационарийн шинжилгээ	80
Хавсралт 10.	Худалдааны тэнцлийн стационарийн шинжилгээ	82
Хавсралт 11.	БДНБ-ий мөчлөгийн үзүүлэлтийн стационарийн шинжилгээ	83
Хавсралт 12.	Хэрэглээний үнийн индексийн олон хүчин зүйлсийн нөлөөллийн шинжилгээ	84

## ХУРААНГУЙ

Манай улсад сүүлийн жилүүдэд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тасралтгүй өссөөр байгаа нь хүмүүсийн амьдралд бодит дарамт болоод зогсохгүй цаашид ч үнийн өсөлтийн хязгаарлаж чадахгүй байх гэсэн болгоомжлол, бухимдлын бас нэг шалтгаан болж байна. Үнийн өсөлтийн улмаас цалин, тэтгэвэрт авч байгаа мөнгөний худалдан авах чадвар буурсаар байна. Хүмүүс жилийн, магадгүй сарын өмнө 100 мянган төгрөгөөр худалдан авч байсан зүйлээ одоо 130 мянган төгрөгөөр ч худалдан авч чадахгүй болж байгааг “мөнгөний худалдан авах чадварын бууралт” хэмээн нэрлэдэг. Энэ бол инфляцийн хор хохирол юм.

Албан ёсны статистик мэдээгээр 2006 онд 6.0 хувьтай байсан инфляци 2007 онд урьдчилсан байдлаар 15.1 хувь болж өсчээ. Мөлхөж<sup>1</sup> байсан инфляци хүчтэйгээр цогиж<sup>2</sup> эхэллээ. Өрхийн зарлагын<sup>3</sup> 30.4 хувийг эзэлдэг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийн үнэ 2007 оны 12 сард өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн бол, орон, сууц, цахилгаан, дулаан, түлшний үнэ 11.3 хувиар өсчээ. Эдгээр бараа, үйлчилгээ нь айл, өрхүүдийн наад захын зайлшгүй хэрэглээ учраас хүмүүсийн амьдралд бодитойгоор мэдрэгдэж, хүнд тусч байна.

Нөгөө талаас бидний орлогын үндсэн эх үүсвэр болох цалин сүүлийн 3 жилд 9-26.2 хувиар өсчээ. Цалингийн өсөлт нь үнийн өсөлтийг гүйцэхгүй байна. Төгрөгийн хадгаламжийн жилийн дундаж хүү хугацаанаасаа хамааран 6-10.2 хувь байхад инфляци 15.1 хувь болсон нь хадгалуулсан мөнгөний худалдан авах чадвар ч мөн буурсаар байгааг илэрхийлж байна.

Үйл явц энэ маягаар үргэлжилсээр байвал нөхцөл байдал цаашид улам хүндрэх төдийгүй эдийн засаг хямрах аюул ч нүүрлэж байна. Хүмүүсийн худалдан авах чадвар муудсанаар нийт эрэлтийг багасгаж, бараа, үйлчилгээний борлуулалт, үйлдвэрлэгчийн ашиг буурч, үйлдвэрлэлээ хорогдуулж, ажиллагсдаа ч халж болох юм. Өөрөөр хэлбэл инфляцийн өсөлт нь дараа үедээ ажилгүйдлийг дагуулах уршигтайг анхаарах хэрэгтэй болж байна.

Дүн шинжилгээнээс харахад инфляци нь макро эдийн засгийн мөчлөгийн өсөлттэй үед илэрч байна. Манай орны хувьд эдийн засгийн

---

<sup>1</sup> Инфляци нэг оронтой тоогоор хэмжигдэж байвал мөлхөө инфляци гэдэг

<sup>2</sup> Харин хоёр оронтой тоогоор хэмжигдэж байвал цогийн инфляци гэдэг

<sup>3</sup> Хотод 40 хувь, хөдөөд 26 хувийг эзэлдэг

мөчлөг нь мал аж ахуй давамгайлсан хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, энэхүү үйлдвэрлэлийн улирлын мөн чанараар тодорхойлогддог. Сүүлийн гурван жилийн туршид мөчлөгийн өсөлтийн үе ажиглагдаж, эдийн засаг тодорхой хэмжээнд “*хөөрөлтийн төлөвт*” оржээ. Эдийн засгийн голлох салбаруудын өсөлт татварын орлогыг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн олон төрлийн тэтгэлэгийг урамшуулж, бүхэлдээ эрэлтийн инфляци үүсэх шалтгаан болжээ. Мөн дэлхийн зах зээл дээр хүнсний бүтээгдэхүүний хомсдол үүссэн, нефть бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнээс манай гол импортлогч хоёр хөрш оронд сүүлийн саруудад инфляци хурдацтай өссөн нь худалдааны нэн хараат манай эдийн засагт шууд импортлогдож байна. Энэхүү эдийн засгийн ерөнхий төлөв дээр мөнгөний нийлүүлэлт, цалин, бензиний үнэ, валютын ханшийн өсөлт инфляцид хүчтэй нөлөөлөл үзүүлж байна.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан үзвэл манай улсын инфляцид мөнгөний нийлүүлэлт, төсвийн цалингийн өсөлт, бензиний үнэ нөлөөлж байгаа ч эдгээрийн цаана эдийн засгийн салбарын онцлогоос хамаарсан мөчлөгийн нөлөөлөл нуугдаж байна. Салбарын бүтцээс хамаарч байгаагийн тод илрэл нь инфляцийн сар, улирлын хэлбэлзэл юм. Тиймээс мах, гурил, нефть бүтээгдэхүүний үнийг тогтворжуулснаар инфляцийг шийдэж чадахгүй.

Харин инфляцитай “тэмцэхийн тулд” эдийн засгийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн урт хугацааны цогц бодлого авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Гэвч энэ нь богино хугацааны бодлого хэрэггүй гэсэн үг биш юм. Иймд

- инфляцийг “зөөлрүүлэх” зорилготой богино хугацааны бодлогын арга хэмжээ,
- дунд хугацаандаа үр дүнгээ өгөх цаашдын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг дэмжих дунд хугацааны бодлого
- урт хугацаандаа эдийн засгийн бүтцийг байгаль орчин болон гадны зах зээлээс аль болох хараат бус болгон өөрчлөхөд чиглэсэн харилцан уялдаатай бодлогын хувилбар хэрэгтэй хэмээн үзлээ.

Богино хугацааны бодлогын зорилго нь “*Тухайн үеийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн үнийн өсөлтийг хязгаарлахад чиглэгдсэн нэг удаагийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд*” оршино. Богино хугацаанд “*гал унтраах*” байдлаар инфляцид хандсан нөхцөлд *сангийн бодлогын хүрээнд зарим барааны нийлүүлэлтийг ихэсгэх, дотоодын үйлдвэрлэгчдэд татаас олгох, гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мөн хэрэглэгчдийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг*



зохицуулах, тухайлбал “*үнийн тааз*”<sup>4</sup> тогтоох аргыг үргэжлүүлэн хэрэглэж болно. Гэвч Засгийн газраас гурилын нөөц үүсгэх зорилгоор импортын гаалийн татварыг тэглэж, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн боловч үнэ нь буурахгүй байгаагаас харахад зөвхөн сангийн бодлогоор асуудал зохицуулагдахгүй байх бүрэн магадлалтай. Иймээс *мөнгөний хатуу*<sup>5</sup> бодлогоор дэмжих хувилбар байж болох юм. Гэхдээ эдгээр арга хэмжээ нь урт хугацаанд зах зээлийн эдийн засгийн голдрилыг эвдэх, далд эдийн засаг үүсэх, авилгал, хээл хахуулийг нэмэгдүүлэх нөхцөл болох магадлалтай тул ганц нэг удаа хэрэглээд, цаашид аль болох зайлсхийх шаардлагатай. Төрөөс энэ чиглэлийн бодлогууддаа зах зээлийн хэрэгслүүдийг (тухайлбал, эрэлтийг хязгаарлах, үйлдвэрлэлийг дэмжин нийлүүлэлтийг ихэсгэх гэх мэт) ашиглах нь цаашид хор хохирол бага байх болно.

Дунд хугацааны бодлогын зорилго нь “*цаашид эдийн засгийн салбарын бүтцийг өөрчлөх, дотоод өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үндэс суурийг тавих, макро эдийн засгийн удирдлага зохион байгуулалтыг ил тод, тууштай болгох, техник, технологи, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд*” чиглэнэ. Дунд хугацаанд төрийн институцуудын чадавхийг сайжруулах, үйл ажиллагааг ил тод болгох замаар бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр нөлөөтэй болгож, иргэдийн бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх чиглэлийг барих нь зүйтэй. Түүнчлэн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлогыг өөрийн орны онцлог нөхцөлд нийцүүлэн боловсруулах, цаашид ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг давамгайл болгоход чиглүүлэх шаардлагатай.

Урт хугацааны бодлого нь “*Эдийн засгийн салбарын бүтцийг дундаж ба өндөр хөгжилтэй орны жишиг рүү дөхүүлэн, хараат байдлаас ангижрах, эдийн засаг, бизнесийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд*” чиглэгдэх ёстой. Аж үйлдвэрийг бүхэлд нь болон түүний дотор нарийн технологид суурилсан, оюуны багтаамжтай, экспортын чиглэлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд баримжаалсан чиглэл, салбаруудыг дэмжсэн хөрөнгө оруулалт, хүний нөөцийн бодлого, техник, технологийн шинэчлэлийн стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

---

<sup>4</sup> Тодорхой нэрийн бараануудын хувьд үнийн дээд заагийг тогтоох бодлого

<sup>5</sup> Мөнгөний нийлүүлэлтийг багасгах болон тодорхой түвшинд барих



# БҮЛЭГ 1

## СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ, ҮНДСЭН ОЙЛГОЛТ, УХАГДАХУУН

### 1.1 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

1990-ээд оныг хүртэл буюу социализмын үед бараа, үйлчилгээний үнийг төрөөс тогтоон, тэрхүү тогтоосон үнэ нь ямар нэг хэлбэлзэлгүй олон жилийн туршид тогтмол байсан тул уг бүтээгдэхүүний “оноосон” нэр болох тохиолдол олонтаа байв. Тухайлбал бид *есийн тос, хорин дөрвийн чихэр, наян мөнгөний печень, дөчин тавын гутал* гэх мэт “нэрсийг” санаж байгаа байх. Гэтэл өнөөдөр энэ нэрс түүх болон үлдэж, бараа, үйлчилгээний үнэ өөрчлөгдөн хувьсдаг зүйл гэдэгтэй монгол хэрэглэгчид маргахааргүй болжээ. Харин бараа, үйлчилгээний үнэ чухам юунаас болж хэлбэлзэж байгаа, түүнийг хэрхэн тогтоогоод байгаа тухай маргах нь их болов.

Бараа, үйлчилгээний үнэ тасралтгүй өсөх үзэгдлийг эдийн засгийн онолд **инфляци** хэмээн нэрлэдэг. 1991 оноос хойш Үндэсний Статистикийн Газар /УСГ/, Олон Улсын Валютын Сангийн /ОУВС/ аргачлалаар манай улсын инфляцийн түвшинг хэрэглээний үнийн индекс /ХҮИ/-д тулгуурлан тооцдог болсон. ХҮИ нь хэрэглэгчдийн худалдан авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ нь дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Зүйрлэвэл, нэг өрхийн сарын туршид хэрэглэдэг өргөн хэрэглээний барааг нэг сагсанд цуглуулж, кассанд нийт үнийг нь бичүүлээд, дараа нь сар, улирал бүрт нөгөө л бүтээгдэхүүнүүдээ “сагсандаа” хийгээд нийт үнийг нь бичүүлээд байхад мөнгөн дүнд нь өсөлт, бууралт гарч байгаа эсэхээр ХҮИ-ийг тооцоолж болно. ХҮИ нь нэг өрхийнхийг биш, нийт өрхүүдээр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулах үзүүлэлт юм. Манай улс энэ индексийг тооцох аргачлалаа одоогоор дөрвөн удаа өөрчлөөд байна. Үүнд:

- 1991-1995 онд 123 нэрийн бараа, үйлчилгээгээр, (1991 оны 1 сарын 16-ны үнийг суурь үнэ болгон) тооцоолж байлаа

- 1996-2000 онд 205 нэрийн бараа, үйлчилгээгээр, (1995 оны 12 сарыг суурь үе болгон Лас-Пейресийн стандарт индексийг ашиглан) тооцож байв. Мөн 1997 оноос сар тутам хэрэглээний үнийн судалгааг аймгийн төвүүдэд 116 нэрийн бараа, үйлчилгээг хамруулан явуулж, үнийн мэдээг дамжуулан авч, индексийг ҮСГ-т тооцон гаргадаг болсон.
- 2001 оноос хэрэглээний сагсны нэр төрлийг 239 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 139 нэр төрөл) 2000 оны Өрхийн орлого, зарлагын судалгааны зардлын жингээр, (2000 оны 12 дугаар сарын үнийг суурь үе болгож) Лас-Пейресийн хувиргасан индексээр ХҮИ-ийг тооцдог болсон
- 2006 оноос 287 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 194 нэр төрөл) Өрхийн орлого, зарлагын 2004 оны судалгааны зардлын жинг ашиглан, (2005 оны 12 дугаар сарын үнийг суурь үе болгож), Лас-Пейресийн хувиргасан индексээр тооцож байна.

ҮСГ-ын болон Нийслэлийн Статистик Мэдээлэл Судалгааны Газар, дүүргүүдийн үнэ хариуцсан мэргэжилтнүүд хэрэглээний үнийн түүвэр судалгааг нийт 90 гаруй дэлгүүр, зах, үйлчилгээний газруудаар сар бүр тогтсон хугацаанд явуулдаг бөгөөд хүнсний гол нэрийн 20 гаруй барааны үнийг 7 хоног тутам судалж, ажиглалт хийн, үнийг нь дундажлан тооцоонд ашигладаг.

ҮСГ-ын тооцоолсноор Монголд 1991-2006 онуудад ХҮИ болон жилд шилжүүлсэн инфляцийн түвшин<sup>1</sup> ямар байсныг (Хүснэгт 1.)-д харуулав.

Шилжилтийн эхний жилүүдэд гипер буюу ужигарсан инфляцтай<sup>2</sup> байгаад эдийн засаг сэргэн тогтворжихийн хэрээр буурсаар сүүлийн жилүүдэд мөлхөө инфляцтай<sup>3</sup> болсон байв. Харин 2007 оны дунд үеэс инфляци дахин өсөх хандлагатай болж, хүлээгдэж байгаа байдлаар жилийн эцэст 14-17 хувь байхаар тооцоо гарч байна. Энэ нь төгрөгийн бодит худалдан авах чадварыг бууруулж, орлого багатай өрхүүдийн амьдралд хүндээр тусах болов. Инфляцийг барих гэж оролдохын зэрэгцээ нэмэгдэж байгаагийн цаад учир шалтгааныг тогтоож, эдгээр шалтгааныг хянах чиглэлээр бодлого хэрэгжүүлэх нь нэн чухал болоод байна

---

<sup>1</sup> ХҮИ-ийг өмнөх жилийн мөн үетэй харьцуулсан хувь

<sup>2</sup> Жилд шилжүүлсэн инфляцийн түвшин 3 болон түүнээс дээш оронтой тоогоор хэмжигдэж байвал гипер инфляци гэдэг

<sup>3</sup> Жилд шилжүүлсэн инфляцийн түвшин 10-аас бага бол мөлхөө инфляци гэдэг

## Хүснэгт 1. Хэрэглээний үнийн индекс ба инфляцийн түвшин, 1991-2006 он

Он	Хэрэглээний үнийн индекс, 1991-1-16-100%	Инфляцийн түвшин, хувиар
1990	100.0	
1991	152.7	52.7
1992	649.8	325.5
1993	1838.8	183.0
1994	3057.8	66.3
1995	4681.8	53.1
1996	6768.7	44.6
1997	8156.9	20.5
1998	8646.0	6.0
1999	9507.6	10.0
2000	10279.4	8.1
2001	11099.2	8.0
2002	11291.5	1.6
2003	11821.9	4.7
2004	13120.4	11.0
2005	14361.7	9.5
2006	15219.1	6.0

Эх сурвалж: ҮСГ, Статистикийн эмхэтгэл, 1993-2006

## 1.2 СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ ОЙЛГОЛТ, УХАГДАХУУН

Инфляци нь динамик үйл явц ба үнийн өөрчлөлтүүд нь цаг хугацааны шинж чанарын хувьд ч, нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд ч холимог шинжтэй байдаг. Мөн инфляци нь өөрөө ирээдүйн инфляцийнхаа учир шалтгаан болдог ба түүнийг хүн амын бодит худалдан авах чадварын бууралтыг хэмжих зорилгоор тооцдог. Түүнийг ХҮИ эсвэл дотоодын нийт бүтээгдэхүүний дефляторын өсөлтийн хувиар ихэвчлэн хэмждэг. инфляци нь бизнесийн орчинг тодорхой бус болгож, урт хугацааны бизнесийн үйл ажиллагааг төлөвлөхөд хүндрэл учруулдаг. Түүнээс гадна бизнесээс хамааралгүй тогтмол орлоготой хүмүүсийн амьжиргааны түвшинг бууруулдаг. Онолын хувьд тодорхойлсноор инфляцийн таван үндсэн төрөл байдгийг дурьдвал:

- *эрэлтийн (demand pull)*
- *зардлын (cost push)*
- *бүтцийн (structural)*

- *инерцийн (inertia)*
- *улс төрийн (political)*

зэрэг болно (эдгээрийн талаарх нэмэлт тайлбарыг хавсралт 1-ээс харна уу).

Инфляцийг ихэвчлан сар, жилээр хэмждэг тул эдийн засгийн үйл ажиллагааны идэвхжилттэй холбоотойгоор улиран хувьсдаг. Энэхүү шинж чанарыг нь хугацааны цувааны<sup>4</sup> бүрэлдэхүүн хэсгүүдийн тусламжтай тодорхойлж болдог. Хугацааны цуваа нь *чиг хандлага, улирлын нөлөөлөл, мөчлөг нөлөөлөл, гэнэтийн тохиолдлын нөлөөлөл* гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байдаг.

- Авч үзэж буй хугацааны туршид үзүүлэлтийн утгуудын түвшин буурах, өсөх эсвэл тогтонги байх чиглэлийг илэрхийлсэн бүрэлдэхүүн хэсгийг *чиг хандлага* гэдэг.
- Үзүүлэлтийг сар, улирлаар авсан нөхцөлд түүний утга жил бүрийн ижил сар, улиралд давтагдах ямар нэг шинж чанарыг агуулж байвал *улирлын нөлөөлөл* гэнэ.
- Хугацааны цувааны жилээс дээш үетэй хэлбэлзэх шинж чанарыг *мөчлөг нөлөөлөл* нь хэмээдэг
- Харин маш богино хугацаанд урьдчилан таагдашгүй үзэгдэл, үйл явцын үр дүнд хугацааны цувааны өмнө авч үзсэн бүрэлдэхүүн хэсгүүд шинж чанараа алдан, утга нь өөрчлөгдөхийг *гэнэтийн тохиолдлын нөлөөлөл* болно

Эдгээр шинж чанарыг бүрэлдэхүүн хэсгийг ялгах энгийн аргын тусламжтай тогтоодог. Илүү нарийвчилсан шинжилгээг хугацааны цувааны эконометрик аргуудын тусламжтай хийж болно. Инфляцийн түвшин хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдөж байгааг судлахаас гадна түүнд эдийн засгийн ямар үзүүлэлтүүд, тухайлбал ажилгүйдэл, цалин, төсөв болон гадаад худалдааны тэнцэл хэрхэн нөлөөлдгийг онолын үндэслэлтэй авч үзэж, тэдгээрийн нөлөөллийг олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр тогтоож болдог.

Орчин үед инфляцийн эсрэг хэрэгжүүлэх мөнгөний бодлогын гурван хувилбар байдаг. Үүнд:

- Тейлерийн дүрэм (Taylor rule) буюу инфляци ба ажилгүйдлийн холбоог ашиглан урт болон дунд хугацааны хүүгээр дамжуулан удирдах бодлогын хувилбар

---

<sup>4</sup> Сонгож авсан нэг объектын цаг хугацааны дараалсан агшингуудад харгалзах үзүүлэлтийг хугацааны цуваа гэдэг.

- Инфляцийг онилсон (Inflation target) бодлого – дунд хугацааны инфляцийн түвшинг зарлаж Төв Банк үйл ажиллагаагаа түүнд чиглүүлэх бодлогын хувилбар
- Нэрлэсэн орлогод чиглэсэн (Nominal income target) бодлого – ДНБ-ийг тодорхой түвшинд хүргэх зорилтот бодлого

гэсэн хувилбарууд багтдаг (үүнийг мөнгөний эдийн засгийн сурах бичгээс дэлгэрүүлэн харж болно).


Үүнээс гадна сангийн бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан инфляцийн эсрэг бодлогыг хэрэгжүүлдэг. Энэхүү бодлогын хувилбар нь эрэлтийг хязгаарлах чиглэлд хүн амын орлогын татварыг нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг багасах хумих бодлого байхаас гадна нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, пүүс, компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих, дэд бүтэц, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх зэрэг тэлэх бодлого байж болно. Мөн үнийг барих захиргааны аргуудын нэг болох үнийн тааз тогтоох аргыг ч ашиглаж болдог.

### **1.3 БОДЛОГЫН АСУУДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

Манай Улсын инфляцийн түвшин 1992-2002 оны хооронд тасралтгүй буурч, 2002 онд 1.6 хувьд хүрсэн боловч, 2003 оноос дахин өсч, 2004 онд 11 хувь, 2005 онд 9.5 хувь, 2006 онд 6.0 хувь болов. Түүнээс гадна 2007 оны дундаас инфляци эрс өсч, өргөн хэрэглээний бараа үйлчилгээний үнэ өдрөөс өдөрт өссөөр, цалингийн нэмэгдлийг ач холбогдолгүй болгож, эдийн засагт тодорхой бус байдал ихэсгэж, нийгэмд бухамдал үүсгэж байна (Зураг 1).

Огцом нэмэгдэж байгаа инфляцийн сөрөг нөлөөллийн улмаас нийгмийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх бодлогууд “үнэгүйдэж”, хүмүүсийн амьжиргааг дэмжих зорилготой хөтөлбөрүүд бодитой ач холбогдлоо мэдрүүлж чадахгүй байна. Нэг талаас цалин нэмэгдэхийг дагаад инфляци өсдөг, нөгөө талаас инфляци өсөөд байгаа учраас цалин хөлсөө нэмэх шаардлага дахин, дахин тулгарсаар байх гаж гэмээр харилцан хамаарлын цаана оршиж буй шалтгаануудыг судалж тогтоосноор өнөөдөр монголчууд бидэнд олдож байгаа төсвийн орлогын таатай нөхцөлийг ард иргэддээ өгөөжтэйгээр ашиглаж боломж гарч ирэх юм. Тиймээс инфляцийг үүсгэж, ихэсгэж байгаа гол шалтгаануудыг тогтоож, үүний үндсэн дээр манай орны онцлог нөхцөлд тохирсон инфляцийн эсрэг макро эдийн засгийн бодлогын оновчтой хувилбар боловсруулан, олон нийт, бодлого боловсруулагчдын дунд хэлэлцүүлэх нь чухал болоод байна.

Зураг 1. Жилд шилжүүлсэн инфляцийн түвшин, 1996-2007 он



#### 1.4 СУДАЛГААНЫ АСУУЛТУУД

Монголд өнөөдөр эрчимтэй өсөн нэмэгдэж байгаа инфляцийг хянах, зогсооход чиглэсэн бодлогын оновчтой ямар хувилбарууд байна вэ гэсэн судалгааны үндсэн асуултад хариулт олохын тулд инфляцид нөлөөлж байгаа хүчин зүйлсийг таван төрлийн инфляцийн шалтгаантай уялдуулан дараах нөлөөллүүдийн хүрээнд бүлэглэн асуудлуудыг судалж үзэв. Үүнд:

- **Мөнгөний тэлэх бодлогын нөлөөлөл.** Сүүлийн жилүүдийн хурдацтай нэмэгдэж буй мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, мөн гадаад валютын эсрэг дотоодын мөнгөн тэмдэгт суларч байгаа байдал буюу гадаад валютын ханшийн чангаралт
- **Сангийн тэлэх бодлогын нөлөөлөл.** Төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн өсөлт, нийгмийн шинжтэй олон арга хэмжээнд зарцуулагдаж буй мөнгөний өсөлт
- **Гадаад зах зээлийн нөлөөлөл.** Гадаадаас импортлогдон орж ирж буй үйлдвэрлэлийн нөөцүүдийн болон түүхий эд материалын үнийн өсөлт
- **Эдийн засгийн дотоод хүчин зүйлс.** Манай орны эдийн засгийн салбарын бүтэц, түүний үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн мөчлөгийн өсөлт

Эдгээр болон бусад хүчин зүйлсийн аль нь манай орны хувьд ажиглагдаж буй инфляцийн өсөлттэй хамгийн хүчтэй хамааралтай байгааг тооцоолон судалснаар инфляцийн эсрэг бодлогын оновчтой хувилбар боловсруулах боломжтой болно гэж үзлээ.



## 1.5 СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ

Манай орны хувьд мөнгөний бус шалтгаантай инфляци илүү давуу байгаа гэж судлаач миний бие ажигласны үндсэн дээр мөнгөний нийлүүлэлтийг эрэлттэй нь уялдуулан хийж, богино хугацаанд бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, харин дунд болон урт хугацаанд үйлдвэрлэлийн салбарын бүтэц, гадаад худалдааны нөхцөлийг сайжруулахад чиглэсэн макроэдийн засгийн бодлого явуулах замаар инфляцийг бууруулах боломжтой гэсэн таамаглалыг энэ судалгааны хүрээнд гарган тавьж байгаа болно. Энэхүү таамаглалын дагуу инфляцтай тэмцэхийн тулд одоо хэрэгжүүлж байгаа богино хугацааны бодлогын арга хэмжээний зэрэгцээ дунд болон урт хугацаанд үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөхөд чиглэсэн зөөлөн дэд бүтцийг боловсронгуй, хатуу дэд бүтцийг сайжруулах хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлбэл эдийн засаг харьцангуй тогтворжино хэмээн үзэж байна.

## 1.6 ХУВЬСАГЧИД

Эдийн засгийн онолд инфляци нь харьцангуй их судлагдсан асуудал юм. Мөн инфляцийн эсрэг бодлогын олон хувилбар боловсруулж, улс орнуудад туршиж байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд ном зүйн тойм, манай орны хувьд өмнө нь хийгдсэн судалгааны ажлууд, эдийн засгийн онолын дүгнэлтүүдэд тулгуурлан инфляцийн учир шалтгаан, үр дагаврын хувьсагчдыг дараахь байдлаар ангилан авч үзэв.

Учир шалтгааны хувьсагчдыг нөлөөлөлд өртөх буюу өөрчлөгдөх боломжит хугацаа, бодлогын арга хэрэгсэл талаас нь гурав ангилав. Бодлого судлалд бодлого, хөтөлбөр, тодорхой арга хэмжээгээр дамжуулан хувирган өөрчилж, эерэг үр дүнд хүргэж болох хүчин зүйлийг *бодлогын хувьсагч* гэж, харин удаан хугацааны орчны болон зорилтот хөтөлбөр, цогц нөлөөллийн үр дүнд хувирч, хувьсах нийгэм, соёлын хийгээд түүхэн хүчин зүйлсийг *нөхцөл байдлын хувьсагч* хэмээн үздэг. Учир шалтгааны хувьсагчдад нөлөө үзүүлэх замаар өөрчлөхийг зорьж буй эцсийн гарцыг илэрхийлсэн үзүүлэлтийг *үр дүнгийн хувьсагч* гэж нэрлэдэг. Бид судалгаандаа учир шалтгааны хувьсагчдыг *нөхцөл байдлын хувьсагчид ба завсрын зорилгыг хэмжих хувьсагч* гэж хоёр хуваан авч үзэв.

Энд бодлогын хувьсагчид нь мөнгөний болон сангийн бодлогын арга хэрэгслүүд байгаа бол завсрын зорилгыг хэмжих хувьсагчид нь макро эдийн засгийн удирдлага, зохион байгуулалт, техник, технологи, хүний нөөц, зөөлөн дэд бүтцийн асуудлуудаар тодорхойлогдоно. Харьцангуй хадмал хүчин зүйлс буюу нөхцөл байдлын хувьсагчдаар манай орны

эдийн засгийн онцлогуудыг илэрхийлсэн голлох салбаруудын байдал, үндэсний эдийн засагт учирч буй бэрхшээл зэргийг авч үзлээ /Хүснэгт 2/.

## Хүснэгт 2. Бодлогын судалгааны хувьсагчид

Учир шалтгааны буюу тайлбарлагч хувьсагчид			Үр дүнгийн буюу тайлбарлагдагч хувьсагч
Нөхцөл байдлын хувьсагчид/ стратегийн хувьсагч	Завсрын зорилгыг хэмжих хувьсагчид/ тактикийн хувьсагч	Бодлогын хувьсагчид/ үйл ажиллагааны хувьсагч	
А. Байгаль цаг уураас хэт хараат, улирлын шинж чанартай хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	А. Албан институцийн зохицуулалт, макро эдийн засгийн удирдлага, зохион байгуулалт	А. Мөнгөний нийлүүлэлт Б. Хүүний түвшин	Хэрэглээний үнийн индексийн өсөлтөөр тооцсон инфляцийн түвшин
Б. Баялаг бүтээх чадвар нь хязгаарлагдмал, дэлхийн зах зээлээс хараат уул уурхайн үйлдвэрлэл	Б. Хүний нөөцийн чанар, бодлого, зохицуулалт В. Эдийн засгийн салбаруудын бодлого, хөтөлбөр	В. Валютын ханш Г. Татвар, татаас	
В. Техник, технологийн хоцрогдолтой аж үйлдвэрийн салбар	Г. Санхүүгийн зах зээлийн хөгжил	Д. Цалин, орлогын хуваарилалт	
Г. Үйлдвэрлэлийн салбарын хязгаарлагдмал байдлаас үүдэлтэй, импортоос өндөр хамааралтай худалдаа, үйлчилгээний салбар	Д. Дэд бүтцийн хөгжил Е. Хот, хөдөөгийн ялгаа	Е. Үнийн зохицуулалтын аргууд	
Д. Үндэсний эдийн засгийн «гачигдлын цагираг»			

### 1.7 СУДАЛГААНЫ ОБЪЕКТ, ТҮҮВРИЙН ХҮРЭЭ, ХЭМЖЭЭ

Судалгааны үндсэн объектоор Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцоо, түүний доторх мөнгө, санхүүгийн болон бодит секторын

харилцааг сонгон авч үзэв. Судалгааны үндсэн таамаглалыг шалгахын тулд 1996 оноос хойших нийгэм, эдийн засгийн улирал, сарын үзүүлэлтүүдийг ашиглан шинжилгээ хийв.

## 1.8 СУДАЛГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ

- Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлүүдийг тодорхойлохын тулд макро эдийн засгийн инфляцийн онолууд болон бусад олон орны судлаачдын эмпирик ажлуудыг нэгтгэн дүгнэж, харьцуулалт хийв
- Инфляцийн түвшний цаг хугацааны онцлогийг илрүүлэх зорилгоор хэрэглээний үнийн индексийн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлж, детерминистик болон стохастик бүтцийг тогтоон, эдийн засгийн тухайн үеийн нөхцөлүүдтэй холбон авч үзэв
- Сарын инфляцийн тархалтын хуулийг тодорхойлж, тодорхой итгэх магадлалын хувьд өөрчлөлтийн заагийг тогтоов.
- Хэрэглээний үнийн индексийн прогнозын нэг тэгшитгэлт чиг хандлага, сарын нөлөөлөл бүхий ARMA загварыг боловсруулж, бүрэлдэхүүн хэсгийн ангиллыг дахин нягталсан ба оны сүүлийн саруудын инфляцийн түвшинг прогнозлов.
- Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсээр сонгон авсан мөнгөний нийлүүлэлт, цалин, америк долларын төгрөгтэй харьцах ханш, A93 бензиний үнийн индекс, гадаад худалдааны тэнцэл, хөрш орнуудын хэрэглээний үнийн индекс зэрэг үзүүлэлтүүдийн хувьд хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгийг ангилан, дүгнэлт гаргав
- Хэрэглээний үнийн индекс болон дээр сонгосон тайлбарлагч үзүүлэлтүүдийн хувьд бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн хамаарлын зэргийг тогтоосноос гадна, үзүүлэлт бүрийн интегретэдийн эрэмбэ, учир шалтгаан, үр дагаврын холбоог тогтоон, эцэст нь олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээний тусламжтай инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийн эмпирик эконометрик загвар боловсруулан, дүгнэлт гарав.
- Хэсгийн корреляцийн шинжилгээгээр сонгосон хүчин зүйлүүдийн тухайлсан нөлөөллүүдийг тогтоов.
- Дээрх шинжилгээнүүдийн үр дүнд Монгол Улсын инфляцийн эсрэг бодлогын үндсэн чиглэлийг богино, дунд, урт хугацаанд ямар байх талаар хувилбар боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлов.

### 1.9 СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

- Хэрэглээний үнийн индексийн бүрэлдэхүүн хэсгүүдийг шилжүүлэн дундажлах арга болон эконометрик аргуудаар ялган, эдийн засгийн бүтцийн онцлог, гадаад эдийн засгийн нөлөөлөл, гэнэтийн болон бодлогын өөрчлөлт зэргээс хэрхэн хамаарч байгааг тогтоов.
- Сарын инфляцийн түвшний тархалтын хуулийг MATLAB программ хангамжийг ашиглан, хамгийн их үнэний хувь бүхий үнэлгээгээр тодорхойлов
- Хэрэглээний үнийн индексийн прогнозын загвар боловсруулахдаа хугацааны цувааны нэг тэгшитгэлт загваруудыг ашиглав.
- Инфляц-цалин, инфляц-валютын ханш, инфляц-нефть бүтээгдэхүүний үнэ, инфляц-мөнгөний нийлүүлэлт, инфляц-эдийн засгийн мөчлөг, инфляц-гадаад худалдааны тэнцэл гэсэн хосуудын учир шалтгаан, үр дүнгийн хамаарлыг тогтоохдоо Гранжерийн учир шалтгааны тестийг ашиглав.
- Зарим үзүүлэлтийн хамаарлын зэргийг хосын болон хэсгийн корреляцийн коэффициентийг ашиглан тогтоов.

### 1.10 МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Судалгааны ажилд хоёрдогч эх үүсвэрийн мэдээллүүдийг ашигласан. Эдгээр мэдээллийг Үндэсний Статистикийн Газар, Монголбанк зэрэг байгууллагуудын сарын болон жилийн тайлан, эмхэтгэлээс авсан болно.

Мэдээллийн үндсэн сувгууд:

- *Статистикийн газраас боловсруулсан үзүүлэлтүүдийг тооцох аргачлалууд*
- *Статистикийн жилийн эмхэтгэл, сарын бюллетень*
- *Монголбанкны жилийн тайлан*
- *Хууль, тогтоомжийн эмхэтгэл*
- *Чиглэлийн яамдуудын мэдээлэл*
- *Хөрөнгийн биржийн мэдээлэл*
- *Интернет вэб хуудсууд*
- *Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангийн тайлан, мэдээлэл*

## БҮЛЭГ 2

### ИНФЛЯЦИЙН ХОЛБОГДОЛТОЙ ОНОЛЫН БОЛОН ЭМПИРИК СУДАЛГААНЫ ТОЙМ

Макроэдийн засгийн онолын олон урсгалууд өөрийн үзэл баримтлал, зарчмуудад тулгуурлан инфляцийн үүсч байгаа шалтгааныг ангилж, эдийн засагт нөлөөлөх сувгуудыг авч үзсэн байдаг. Онолын үзэл баримтлуудын үндсэн дээр инфляцийг ялгах шинжүүрийг гаргадаг. Инфляцийн онолыг богино ба урт хугацааны, хаалттай ба нээлттэй эдийн засгийн, төгс ба төгс бус өрсөлдөөний, сангийн ба мөнгөний, өндөр ба нам инфляцийн онолууд гэх мэт ангилдаг.

#### 2.1 ОНОЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

**Эдийн засгийн сонгодог онолын инфляцийн тайлбар.** Сонгодог (David Hume, Adam Smith, David Ricardo, John Stuart Mill) болон шинэ сонгодог (Leon Walras, Alfred Marshall, Arthur C.Pigou) эдийн засагчид инфляцийг тайлбарлахдаа мөнгөний тооны онолыг ашигладаг. Мөнгөний тооны онол нь бүх худалдагдах барааны өртөг нь худалдан авалтын нийт дүнтэй тэнцүү гэж үздэг. Өөрөөр хэлбэл мөнгөний хэмжээ нь бараа, үйлчилгээний үнийн дүнтэй уялдаж байх шаардлагатай гэж үздэг.

Богино хугацаанд мөнгөний эргэлтийн хурд, бодит үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол гэсэн сонгодог эдийн засагчдын таамаглалаар бусад хүчин зүйлс тогтмол байхад мөнгөний нийлүүлэлтийг хоёр дахин өсгөвөл үнийн түвшин мөн хоёр дахин өснө гэсэн дүгнэлтийг хийж болно. Мөнгөний зах зээл дээр илүүдэл нийлүүлэлт хийгдвэл бараа, үйлчилгээний зах зээл дээр эрэлтийн илүүдэл үүсдэг. Үүнээс шалтгаалан сонгодог ба шинэ сонгодог эдийн засагчид инфляцийг мөнгөний үзэгдэл хэмээн тайлбарладаг. Мөнгөний нийлүүлэлтийг бууруулснаар инфляцийг бууруулж болно гэж үздэг.

**Эдийн засгийн Кейнсийн онолын инфляцийн тайлбар.** John Maynard Keynes (Кейнс, 1936) *“Ажил эрхлэлт, хүү, мөнгөний ерөнхий онол”* зохиолоо тогтмол үнийн түвшинтэй үед бүрэн бус ажил эрхлэлтийн таамаглалд үндэслэн бичсэн. Энд инфляцийн динамик шинжилгээний загварчлал байхгүй. Кейнс (1940) инфляцийн монетарь загварын альтернатив хувилбар болох хөдөлмөрийн зах зээл дээр ихэнх үнэ тогтмол тохиолдолд эрэлтийн инфляцийн загварын нэг хувилбар боловсруулсан. Үүнийгээ тэрээр “Inflation gap” буюу “Инфляцийн зөрүүний” загвар гэж нэрлэсэн. Энэ загвартаа тэр орлогын дахин хуваарилалтын процессийг авч үзсэн. Энэхүү процесс дэх инфляцийн үзэгдэл нь доогуур хадгалах ахиу хандлагатай болон бага татвартай цалин авагчдаас өндөр хадгалах ахиу хандлагатай, өндөр татвартай үйлдвэрлэлийн сектор луу орлого шилжиж, үнийн хөөрөлт үүссний үр дүн юм хэмээн тайлбарлажээ.

Дайны үеийн нөхцөл байдал шиг нийт эрэлтийн хүлээгдээгүй өсөлт нь бүрэн ажил эрхлэлттэй нөхцөл дэх үнийг өсгөдөг бөгөөд нөгөө талаас нэрлэсэн цалин богино хугацаанд тогтмол байх учраас пүүсүүдийн хувьд хүлээгдээгүй ашгийг бий болгодог. Ашиг нэмэгдснээрээ бүтээгдэхүүний зах дээр нэмэлт илүүдэл эрэлтийг бий болгодог. Гэсэн хэдий ч бүтээгдэхүүний зах зээл дээрх анхдагч илүүдэл эрэлтийг хангах пүүсүүдийн оролдлого нь хөдөлмөрийн зах зээл дээр илүүдэл эрэлтийг бий болгоно. Бүрэн ажил эрхлэлттэй үед үйлдвэрлэгчдийн хоорондох өрсөлдөөний үр дүнд нэрлэсэн цалинг анхны түвшин дэх бодит цалингийн хэмжээнд хүртэл өсгөдөг. Бодит цалингийн өсөлт нь бүтээгдэхүүний зах зээл дээр шинэ эрэлтийг бий болгох ба үр дүнд нь дахин үнэ өсдөг.

Хэрвээ цалингийн хожимдлын механизм хэвээр байвал чухал ач холбогдолтой орлогын бодлогыг хэрэгжүүлэх замаар хатуу, чанга байдлыг бууруулж, нийт эрэлтийг багасгаснаар л үгүй болгох инфляцийн гинжин өөрчлөлт бий болдог гэж тайлбарлажээ.

**Шинэ Кейнсийн болон монетарь хандлагын инфляцийн тайлбар.**

Кейнсийн “Инфляцийн зөрүүний” загвар нь богино хугацаанд цалин уян хатан биш байх нөхцөл дэх эрэлтийн талын загвар байсан. Гэвч мөнгөний зах зээлийн хөгжлийн тухай юу ч тэмдэглээгүй. Түүний инфляцийн мөнгөний бус, эрэлтийн хандлага нь зардлын инфляцийн зарим аргумент юм. (Humphrey (1981)). Шүүмжлэгчид нийлүүлэлтийн талын гэнэтийн өөрчлөлтөөс бий болсон инфляцийн нөлөө гэж хүлээн зөвшөөрдөг ч, ихэнх Кейнсч эдийн засагчид, тухайлбал A.Smithies, G.Ackley, S.Maitai, J.A.Trevithick нар эрэлтийн талын гэнэтийн өөрчлөлтөөс болдог гэж

үзсэн. Arthur Smithies (1942) болон бусад судлаач нар “Инфляцийн зөрүүний” загварыг онолын үндэслэлтэйгээр томъёолсон ба энэхүү тайлбар нь 1970-аад оны дунд хүртэл хүчинтэй байсан.

Бүтцийнхэн, пост-Кейнсүүд, тэнцвэрийн бус хийгээд шинэ-Марксист эдийн засагчид инфляцийн зардлын онолыг томъёолохдоо инфляцийн үйл явц дахь орлогын хуваарилалтын үр нөлөөний үүрэгт онцгой ач холбогдол өгсөн нь Кейнс-Смитиесийн инфляцийн хандлагыг мөн чанарыг тодорхойлсон.

Шинэ Кейнсийн макро эдийн засаг буюу Кейнсийн шинэ сонгодог синтез нь дараахь ажлууд дээр үндэслэдэг. Үүнд:

- 1930-аад оны сүүлч, 1940-өөд оны эхээр Ж.Хикс, Ф.Модилиани нарын хөгжүүлсэн хаалттай эдийн засгийн IS-LM загвар
- 1950-иад оны сүүлээр А.Филлипс, Р.Липсей нарын хөгжүүлж, П.Самуэльсон, Р.Солоу нарын сайжруулсан Филлипсийн муруй онол<sup>5</sup>
- 1960-аад онд хөгжсөн нээлттэй жижиг эдийн засгийн Манделл-Флемингийн загвар<sup>6</sup> хамаарагдана.

Кейнс-Смитиесийн загвар дахь тогтвортой үнэ өсөх асуудал, орлого дахин хуваарилах механизмын талаар стандарт IS-LM загварт тусгагдаагүй. Үүнээс үүдээд шинэ-Кейнсийн IS-LM загварт үнэ тасралтгүй өсөх тухай асуудлыг огт авч үздэггүй. Нөгөө талаас орлогын тодорхойлолтын Кейнсийн болон сонгодог онолын хоорондын ялгаа нь мөнгөний эрэлтийн хүүний мэдрэмж дэх ялгааг багасгадаг. Кейнсийн шинэ сонгодог синтез нь цалин-үнийн хамаарлыг илэрхийлсэн Филлипсийн муруй гэж нэрлэгдэх инфляцийн тэгшитгэлээр дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн динамикийг нэгтгэн авч үздэг. Инфляц, ажилгүйдлийн хооронд сөрөг хамаарал оршин байдаг тул тэнцвэржүүлэгч коэффициент нь сөрөг утгатай байдаг. Эндээс ажилгүйдлийн түвшин доогуур байхад инфляцийн түвшин өндөр байдаг. Ажилгүйдлийн түвшин буурснаар бараа, үйлчилгээний зах зээл дэх хөдөлмөрийн илүүдэл эрэлтийн шинж давамгайлж, эрэлтийн инфляци болно хэмээн тайлбарлаж болно.

Дээрх онолоор 1960-аад оны сүүлч, 1970-аад оны эхэн үеийн стагфляцийн үзэгдлийг тайлбарлаж чадаагүй. Практикт 1973-74 ба 1978-79 онуудын нефтийн үнийн гэнэтийн өөрчлөлтүүд нь тухайн үедээ дэлхий нийтийг

<sup>5</sup> Филлипсийн муруйн талаархи мэдээллийг Fischer(1983), Humphrey(1986), King(2000) ажлуудаас харж болно

<sup>6</sup> Манделл-Флемингийн загвар нь нийт эрэлтийн муруйн шилжилтийн үр дүнд мөнгө-сангийн бодлогын нөлөөл шинжлэхэд ихэвчлэн ашиглагддаг.

хамарсан рецесс буюу зардлын инфляцийн нөлөөг үүсгэсэн. Үүгээр Филипсийн муруйн холбоос нь зохистой бус байсан нь ажиглалтаар нотлогдсон ба 1960-аад оны сүүлээр Монетарист эдийн засагч М.Фридман, Э.Фелпс нар хүлээлтийн нөлөөг Филипсийн муруйн холбоосонд нэмж суулгасан. Урт хугацаанд ажилгүйдэл, инфляцийн хооронд тэнцвэржүүлэгч байхгүй бөгөөд урт хугацааны босоо Филипсийн муруй нь ажилгүйдлийн хэвийн түвшингээр илэрхийлэгддэг. Монетарист эдийн засагчдынхаар инфляцийн хүлээлт нь дасан зохицох хүлээлт байдаг.

***Монетарист болон бүтцийн эдийн засагчдын инфляцийн талаарх маргаан.*** 1960-70 оны инфляцийн учир шалтгааны гол маргаан нь монетарист болон бүтцийн эдийн засагчдын дунд явагдсан. Энэхүү маргаан нь инфляци эрэлтийн болон зардлын алиных нь болох тал дээр төвлөрсөн байдаг. Инфляцийн зардлын талын онолууд нь мөнгөний бус инфляцийн онцлог шинжүүдийг гарсан байдаг. Тухайн нэг бүтээгдэхүүний үнийн ашгийн бүрэлдэхүүн болон нэгжийн зардлын өөрчлөлт зэрэг нийлүүлэлтийн талын нөлөөг авч үздэг.(Humprey, 1998). Инфляцийн бүтцийн хандлага нь зардлын инфляцийн онолын гол хувилбаруудын нэг юм. Энэ нь тухайн орны дэвшилтэт (аж үйлдвэрийн) сектор, уламжлалт (хөдөө аж ахуйн болон экспортын) секторт байдаг онцлог бүтцийн хүчин зүйлүүдтэй инфляцийг холбох санаа бөгөөд Streeten(1962), Baumol (1967)<sup>7</sup> нарын нөлөө бүхий судалгаанд анх авч үзэгдсэн байдаг. Бүтцийн инфляцийн анхны загвар аж үйлдвэр, хөдөө аж ахуйн секторын хоорондын бүтээмжийн ялгаатай байдлыг авч үзсэн Латин Америкийн орнуудын инфляцийг тайлбарласан 1960 оны ажлаас хөгжих эхэлсэн. Ерөнхийдөө тэд уламжлалт сектор нийт эрэлт, гэнэтийн өөрчлөлт, мөнгөнд хугацааны хожимдолтой хариу үйлдэл хийдэг гэсэн үндэслэл гаргасан. Энэхүү хожимдол нь богино хугацаанд ажил эрхлэлт, аж үйлдвэрлэлийн гарцын хэсэгчлэн өсөлтийг бий болгодог. Энэ үеэс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт болон цалин өсдөг. Энэ өсөлт нь хүнсний бүтээгдэхүүний харьцангуй үнийг өсгөдөг. Хөдөө аж ахуйн салбарын өндөр үнэ нь энэ салбар дахь цалингийн өндөр эрэлтийг бий болгодог. Өссөн цалин нь аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний эрэлтийг өсгөх ба энэ механизм нь тасралтгүй үргэлжилдэг. Тухайн загварт нийт нийлүүлэлт нийт эрэлтээсээ нилээд хугацаагаар хожигддог. Энэ хугацаанд нэг секторт гарц хэвээр үлддэг. Тиймээс бүтцийн загвар нь зардлын инфляцийн онол юм.

---

<sup>7</sup> Бүтцийн инфляцийн онолын үндэслэлүүдийг Kirkpatrick, Nixon (1976), Frish (1983), Beckerman (1992) ажлуудаас харж болно



1970 онд инфляцийн Скандиновийн загвар гэж нэрлэгдэх бүтцийн загварын алдартай хувилбар боловсрогдсон<sup>8</sup>. Скандиновийн загварын тусгай өвөрмөц шинж нь Норвеги, Швед зэрэг орнуудад дахь цалингийн өсөлттэй холбоотой юм.

Мөн 1970-аад онд хөгжсөн пост-Кейнсийн онолд богино хугацааны тэнцвэргүй эдийн засгийн тохиолдлыг авч үзсэн<sup>9</sup>. Don Patinkin, Axel Leijonhufvud болон бусад судлаач нар үнийн ашгийн бүрэлдэхүүн, орлогын өсөлт, харьцангуй үнийн өөрчлөлтүүд зардлын инфляцид гол нөлөөг үзүүлдэг хэмээн тайлбарласан байдаг. Шинэ-Марксист болон Латин Америкийн шинэ-бүтцийн инфляцийн онолчид инфляцийг хуваарилалтын зөрчилдөөнөөс үүдэлтэй гэсэн зардлын инфляцийн санаан дээр тулгуурлан тайлбарладаг<sup>10</sup>.

Кейнсч, бүтцийн, пост-Кейнсч, шинэ-Марксист эдийн засагчдын зардлын инфляцийн онолын хувилбар нь харьцангуй үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан ерөнхий үнийн түвшин өсөх тухай хуваарилалтын механизм дээр тулгуурладаг. Хуваарилалтын механизмууд нь харьцангуй үнийн өөрчлөлтийг далд байдлаар илэрхийлдэг ба үнийн ерөнхий түвшний үргэлжилсэн өсөлтийг буюу тогтвортой инфляцийг бий болгодог.

Гэтэл инфляцийн нийлүүлэлтийн талын өөр нэг бүлэг эдийн засагчид газрын тосны үнийн гэнэтийн өөрчлөлт болон үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийн бууралт зэрэг экзоген үзүүлэлтүүдээс шалтгаалсан үнийн түвшний нэгж хугацааны өсөлтийг зөвхөн тайлбарладаг. Импортын инфляци нь мөн нэгж хугацааны гэнэтийн өөрчлөлтүүдэд суурилсан байдаг хэдий ч инфляцийн шалтгааныг тэр бүр тайлбарлаж чаддаггүй. Учир нь нээлттэй эдийн засагт импортын инфляци нь тогтвортой үнийг өсгөдөг механизм гэж батлагддаггүй. Газрын тосны үнийн өөрчлөлтүүд нь ихэвчлэн богино хугацааны шинжтэй байх ба үнийн ерөнхий түвшинд дарамт учруулах тэр үедээ л харьцангуй үнийн түвшин, үйлдвэрлэлийн гарц, ажил эрхлэлтэд түр зуурын нөлөө үзүүлдэг гэж хүлээн зөвшөөрдөг. Инфляцийн зарим нарийн боловсруулсан загваруудад инфляцийн учир шалтгаан нь валютын ханшийн бууралт, төлбөрийн тэнцлийн алдагдал, инфляцийн хүлээлт, засгийн газрын төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлт зэрэг үзүүлэлт болно хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг<sup>11</sup>.

<sup>8</sup> Энэ талаар Edgren (1973), Aukrust (1977), Calmfors (1977) ажлуудаас харж болно

<sup>9</sup> Пост-Кейнсийн инфляцийг тайлбарлах аргуудыг Michal Kalecki, Nicholes Kaldor, Paul Davidson, Hyman P. Minsky болон Sidney Weintraub нарын ажлаас харж болно

<sup>10</sup> Энэ талаар Bresser-Preira, Nakano (1987) болон Saad-Filho, Mollo (1999) ажлуудаас харж болно.

<sup>11</sup> Montiel (1989), Calvo, Vegh (1999), Fielding, Bleaney (2000), ажлуудаас харж болно

Milton Friedman (Милтон Фридман) сайжруулсан мөнгөний тооны онолдоо эдийн засаг дахь бодит нийт гарцын өсөлтийн хувиас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хувь давсан тохиолдолд инфляци болно гэж үзсэн. Монетарист эдийн засагчид инфляцийг бүхэлдээ мөнгөний болон эрэлтийн талын үзэгдэл гэж зөвшөөрдөг. Тэд инфляцийн нийлүүлэлтийн талын аргууд нь нийлүүлэлтийн талын микро эдийн засгийн ажиглалт дээр үндэслэсэн төөрөгдөл юм гэж үздэг. Монетаристууд пүүс болон үйлдвэрлэлийн зардлууд нь инфляцтай холбоогүй, мөнгөний нийлүүлэлтийн өсөлттэй л холбоотой хэмээн авч үздэг.

***Рациональ хүлээлтийн онолынхны инфляцийн тайлбар.*** 1970-аад онд макро эдийн засагт рациональ хүлээлтийн эдийн засагчид болох Robert E.Lucas, Thomas J.Sargent, Neil Wallace, Robert J.Barro, Bennett T.McCallum нар цоо шинэ хувьсгалт санааг оруулсан юм. Төгс бус мэдээлэл ба зах зээл байнгын тэнцвэртэй байх тухай монетарист таамаглалаас эхэлсэн Рациональ хүлээлтийн сургуулийнхан хүмүүс дасан зохицох хүлээлтэнд авагддаг таамаглалын алдааг үргэлж ашиглаад байдаггүй хэмээн мэтгэлцсэн. Эдийн засгийн агентууд өнгөрсөн ба одоогийн бүх мэдээлэлд тулгуурлан рациональ хүлээдэг хэмээн үзсэн. 1960-аад оноос уламжлалт мөнгөний онолчид үнийн хүлээлт алдаатай байгааг хүлээн зөвшөөрч эхэлсэн. Ер нь үнийн хүлээлт нь санамсаргүй зүйл хэмээн үзсэн.

Бизнесийн мөчлөг, үнийн хувьд рациональ хүлээлтийн хандлага нь урт ба богино хугацаанд Филлипсийн муруй босоо байдаг гэж ерөнхийлдөг. Хэрвээ мөнгөний бодлогынхон мөнгөний тэлэх бодлого явуулна хэмээн зарлавал хүмүүс үнэ өснө хэмээн хүлээнэ. Энэ тохиолдолд мөнгөний бодлогыг бүрэн урьдчилан мэдэх тул богино хугацаанд ямар нэгэн бодит нөлөөлөл гарахгүй гэж мөнгөний эдийн засагчид маргадаг. Энэ тохиолдолд зөвхөн төв банк “үнийн гэнэтийн” бэлэг барих арга замыг олж чадвал бодит гарц, ажил эрхлэлтэнд нөлөө үзүүлж чадна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн агентуудын “ирээдүйд тэмүүлсэн” хүлээлт нь урьдчилан мэдээлсэн бодлогыг бүтэлгүйтүүлдэг гэж баталдаг. Хэрвээ бодлого боловсруулагч нар инфляцийн эсрэг бодлого зарласан тохиолдолд хүмүүс тухайн ажлыг засгийн газар бодиттойгоор хийж гүйцэтгэнэ гэсэн итгэл үнэмшил байхгүй бол энэ бодлого үнийг бууруулж чадахгүй. Шинэ сонгодог онолын хүрээнд үнийн хүлээлт нь эдийн засагт бүрэн дүүрэн инфляцийг бууруулахад бодлогын итгэл үнэмшил буюу нэр хүндтэй зайлшгүй холбоотой чухал хэмээн үздэг.

Монетаристууд болон шинэ сонгодог эдийн засагчид улсын төсвийн алдагдлыг төв банк санхүүжүүлснээр мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг хаадаг гэж хүлээн зөвшөөрдөг. Хатуу биш мөнгөний онолын хүрээнд Sargent, Wallace (1981) нар Засгийн газрын төсвийн хязгаарлалт

инфляцийн цаг хугацааны замыг тодорхойлоход зайлшгүй чухал хэрэгтэй гэж үзсэн байдаг<sup>12</sup>. Төсвийн алдагдлын альтернатив санхүүжилтийн аргууд нь сангийн бодлого мөнгөний бодлогоос давуу гэсэн таамаглалын дор ирээдүйд зайлж чадахгүй инфляцийн хугацааг тодорхойлдог.

***Шинэ улс төрийн макро эдийн засагчдын инфляцийн тайлбар.***

Онолууд инфляцийн макро эдийн засгийн тодорхойлогчууд болох мөнгөний хүчин зүйлс, бодит гэнэтийн өөрчлөлт, инфляцийн инерц зэрэг үзүүлэлтүүдийг голлон анхаараад, инфляци үүсч байгаа үйл явц дахь соёл, улс төрийн үйл явц, институтууд зэрэг эдийн засгийн бус хүчин зүйлсийг авч үздэггүй. Инфляцийн потенциал шалтгаан болж байгаа засгийн газрын төсвийн алдагдал нь магадгүй хэсэгчилсэн болон бүрэн байдлаар улс төрийн үйл явцын нөлөө, засгийн газрын төсөв дэх лоббийн үйл ажиллагаануудаас хамаардаг байж болзошгүй юм. Шинэ улс төрийн эдийн засагчид шийдвэр гаргагчдын бодлогын сонголтын улс төрийн мөн чанарыг судалдаг. Шинэ улс төрийн эдийн засагчдын ном бүтээлд сонгуулийн хугацаа, бодлого боловсруулагчдын хэрэгжилт, биелэлт, улс төрийн тогтворгүй байдал, бодлогын итгэл үнэмшил, нэр хүнд, төв банкны хараат бус байдал, инфляцийн үйл явц өөртөө нөлөөлөх байдал зэргийг сонирхох шинэхэн хандлага бий болж байна<sup>13</sup>.

***Инфляцийн учир шалтгаануудыг ангилах нь.*** Эдийн засгийн нийт систем дэх үнийн түвшин гэдэг нь мөнгөөр илэрхийлэгдсэн бараа, үйлчилгээний харьцангуй үнүүд юм. Тиймээс инфляци нь мөнгөний (эрэлтийн талын) болон бодит хүчин зүйлийн (нийлүүлэлтийн талын) хийгээд макро эдийн засгийн удирдлага зохицуулалт, гадаад нөлөөллийн харилцан үйлчлэлийн үр дүнгийн үзэгдэл юм. Эрэлтийн талын гэнэтийн өөрчлөлтийн анхдагч эх үүсвэр нь улсын секторын төсвийн алдагдал юм. Засгийн газрын төсвийн алдагдлын үүрэг болон түүний санхүүжилтийн аргуудын загварчлал нь эдийн засагчдын гол маргаан байдаг. Засгийн газрын орлогын бодит өртөгт инфляциас зугатсан нөлөөлөл, хариу үйлдлийг зөвшөөрсөн орчин үеийн инфляцийн загваруудад татвар хураалтын хожимдол (Olivera-Tanzi effect)-ыг оруулах, засгийн газрын өрийн бодит өртгийг (inflation tax) тооцох аргууд хамрагдах ба санал болгож буй загварын бүтэц нь нилээд нүсэр болдог.

Бодит гэнэтийн өөрчлөлтөөс үүдэлтэй инфляцийн нөлөөллүүдийн судалгаа нь технологийн эдийн засаг, урт хугацааны өсөлтийн онол, ханшийг тодорхойлогч онолууд, бүтээмжийн сөрөг гэнэтийн өөрчлөлт,

<sup>12</sup> Энэ талаархи мэдээллийг <http://politics.ankara.edu.tr/~kibritci/sargewall.html> хаягаас харж болно

<sup>13</sup> Энэ талаар Alesina (1997) болон Drazen (2000) ажлуудаас харж болно

импортолж буй түүхий эд материалтай холбоотой стагфляцийн харьцангуй үнийн гэнэтийн өөрчлөлт, дотоодын валютын сулралт зэрэгтэй холбоотой байдаг.

Үнийн хугацааны зам нь хүлээлт, үнэ, цалингийн уян хатан байдал, эдийн засаг дахь боломжит индексчлэлийн туршлага зэргийн нөлөөллийг харуулдаг. Тиймээс инерцийн хүчин зүйл нь инфляцийн тайлбарлагч хүчин зүйлсийн гурав дахь бүлэг үзүүлэлт болдог.

Инфляцийг тайлбарлагч дараагийн бүлэг хүчин зүйл нь шинэ улс төрийн макро эдийн засгийн үндэслэлүүд юм. Инфляцийн динамик загварт улс төрийн процесс, институцийн үүрэг, бодиттойгоор суусан байх шаардлагатай. Инфляцийн учир шалтгааны хувьд онолын маргаанууд нь санхүүгийн зах зээлийг өндөр хөгжилтэй, хууль, журмын хэрэгжилт сайтай гэсэн таамаглалд үндэслэдэг. Энэ нь маш өндөр инфляцитай хөгжиж байгаа орнуудын байдалтай нийцдэггүй. Тиймээс эдийн засаг дахь улс төр, институцийн хандлага нь тухайн эдийн засаг дахь институт, улс төр, соёлын өөрчлөлтийг тооцсноороо өндөр инфляцийг тайлбарлахад дөхөм болж байна.

Инфляцийг тайлбарлахад эрэлтийн гэнэтийн өөрчлөлтүүд, нийлүүлэлтийн гэнэтийн өөрчлөлтүүд, инерцийн хүчин зүйлс, улс төрийн үйл явц гэсэн дөрвөн бүлэг хүчин зүйлийг нийлмэл, динамик байдлаар авч үзэх нь чухал юм.

## 2.2 ЭМПИРИК СУДАЛГААНЫ ТОЙМ

Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийн эмпирик судалгааны талаар тодорхой тогтсон загвар байхгүй бөгөөд онолын янз бүрийн үзэл баримтлал дээр тулгуурласан ажлууд олон хийгдсэн байдаг. Эдийн засагчид ихэвчлэн инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийг эрэлтийн, нийлүүлэлтийн, импортын гэж ангилан тус, тусад нь судалдаг.

***Америк Нэгдсэн Улсад болон Их Британд хийгдсэн инфляцийн эмпирик судалгаа.*** АНУ болон Их Британд хийгдсэн олонхи эмпирик судалгааны ажлууд нь онолын таамаглалуудыг шалгахад чиглэгдсэн байдаг. Паркин (Parkin) (1973) олон улсад худалдаалагдсан болон дотоод үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний үнийн нийлбэрийг жигнэх байдлаар хүлээгдсэн цалинг загварчилсан бол Гросс (Gross), Лэйдлэр (Laidler) (1975) нар нь гадаад нөлөөллийг шууд нэгтгэсэн байдлаар авч үзсэн.

Блежер (Blejer) (1979), Лэйдэрмэн (Leiderman) (1981) нар хөвөгч валютын ханштай нөхцөлд мөнгөний хандлагын шинжилгээг өргөжүүлсэн.

Мак Кэндлэсс (Mc Candless), Вэбэр (Weber) (1995) нар улсуудын хөлгөн өгөгдлөөр (Gross section data) судалгаа хийж, мөнгөний өсөлт болон инфляци хоёрын хоорондох корреляцийн коэффициент 0.95 байна гэсэн үр дүн гаргасан байна.

Харин Росситер (Rossiter) (1999), Гхали (Ghali) (1999), Палли (Palley) (1999), Эмори (Emory) болон Чанг (Chang) (1996), Даррат (Darrat) (1994), Мэра (Mehra) (1991), Фосу (Fosu) болон Хак (Huc) (1998), Гордон (Gordon) (1998) нар нь Америкийн хувьд үнийн түвшин болон цалин хоорондын учир шалтгааны холбоог авч үзсэн бол Хасан (Hasan) (1999), Сандерс (Sanders) (1994) нар нь Их Британийн хувьд судалжээ. Росситер (Rossiter) (1999), Хасан (Hasan) (1999), Сандерс (Sanders) (1994) нар цалин болон инфляци нь бие биенийхээ учир шалтгаан болдгийг тогтоожээ.

Фосу (Fosu), Хак (Huc) (1988) нар аж үйлдвэрийн салбар дахь үйлдвэрлэлийн ажилчдын орлогыг цалин гэвэл үнийн түвшин нь цалингийн учир шалтгаан болдог гэсэн дүгнэлтийг хийсэн. Эсрэгээр цалин нь аж үйлдвэрийн ажилчдын жилийн дундаж орлогоор хэмжигддэг бол үнийн түвшин болон цалин аль алиныхаа учир шалтгаан болно гэдгийг тэд илрүүлсэн.

Гордон (Gordon) (1988), Даррат (Darrat) (1994) нар дээрх хоёр хувьсагчдын хооронд ямар нэг учир шалтгааны холбоог олоогүй. Гордон (Gordon) (1988) болон Мэра (Mehra) (1991) нар цалингийн өөрчлөлт нь инфляци (ДНБ-ий дефлятор)-ийг тайлбарлахад нөлөөгүй байна гэж дүгнэсэн. Харин үнийн өөрчлөлт нь цалингийн өөрчлөлтийн Гранжер шалтгаан болж байгааг харуулсан.

Мэра (Mehra) (1993) урт хугацаанд нэгж хөдөлмөрийн зардал болон хэрэглээний үнийн индексийн (ХҮИ) хооронд хамаарал оршин байдаг болон урт хугацаанд ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци нь нэгж хөдөлмөрийн зардлын өсөлтийн шалтгаан болж байдгийг тодорхойлсон. Мэра (Mehra) (2000) цалингийн өсөлт нь тогтвортой өсөж буй инфляцтай үед л ирээдүйн инфляцийг тааварлахад туслаж болохыг харуулсан. Гхалли (Ghalli) (1999) Гранжер шалтгаан нь үндсэндээ цалингаас үнэ гэсэн чиглэлтэй байгааг тогтоосон бол Зенетти (Zenetti) (2005) Филлипсийн муруйн үнэлгээгээр цалингийн өсөлт нь ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляцийн Гранжер шалтгаан болж байдгийг харуулсан байна.

***Ирландад хийгдсэн инфляцийн эмпирик судалгаа.*** 1979 онд чөлөөт зах зээлийн систем (EMS)-д орохоос өмнө Ирланд худалдааны ихэнх хувийг нь Их Британий экспортын бараа эзэлдэг, хөршийн эдийн засагтай, тогтмол ханштай улс байсан. Урт хугацаанд Ирландын

инфляци нь гол худалдааны түншлэгч Их Британи инфляцийн түвшин рүү дөхөж байв.

Жери (Geary), Хери (Hery), Прашке (Pratschke) (1970) нар хэрвээ худалдааны түншүүдийн ихэнх нь тогтмол ханштай бол дотоодын цалин Ирландын инфляцид нөлөөлөгч гол хүчин зүйл нь болно гэдгийг харуулах орц-гарцын загвар (input-output model)-ыг боловсруулсан. Жижиг нээлттэй эдийн засаг нь инфляцийг урт хугацаанд доогуур байлгахын тулд дотоодын цалингийн хяналтыг ашиглаж болно гэдгийг энэ шинжилгээ харуулсан. Жери (Geary) (1974)-ийн судалснаар урт хугацаанд иймэрхүү үйл ажиллагаа нь боломжгүй юм гэдэг дүгнэлтэнд хүрчээ.

Филипсийн муруйн шинжилгээнд Жери (Geary) (1976), Паркин (Parkin) (1973) нар тус тусдаа цалин ба үнийн загварын хувилбарыг боловсруулсан. Жеригийн шинжилгээнд цалин, үнийн тэгшитгэлийн алинд ч ажилгүйдлийн түвшин ач холбогдолгүй байсан. Тэрээр үүнийг цалин болон үнийн инфляци нь дотоодын илүүдэл эрэлтээр тодорхойлогддог байна гэж тайлбарласан. Дотоодын болон гадаадын үнийн хоорондох хожигдлын (lag) бүтцийн судалгаа нь Ирландын инфляцид гадаад нөлөөлөл байна гэдгийг гаргасан. Жеригийн шинжилгээ нь дор хаяж 8 улирлын дараа Их Британий инфляци Ирландийн эдийн засагт шилждэгийг тодорхойлжээ.

Жеригийн урт хугацааны хожигдлын (lag) бүтэц нь Брэдли (Bradly) (1977) ажлаар няцаагдсан. Тэрээр Их Британий урт хугацааны шилжилт болон жилийн бүрэлдэхүүн хэсгүүд нь Ирландын ХҮИ-ийг бууруулдаг гэдгийг олж хараагүй.

1961-1977 онуудад тэрээр Эйпэлбаум (Applebaum) (1979)-ийн боловсруулсан санааг хэрэглэсэн бөгөөд Ирландын импорт SOE-д нөлөөлдөг болохыг тогтоосон. Браун (Browne) (1982) ижил өгөгдөл ашиглан өөр арга зүйгээр боловсруулсан бөгөөд Ирландын экспортлогчдын зарим хэсэгт үнийн хүчтэй дэмжлэгийг бий болгож өгсөн.

Ирландын олон улсын шилжилтийн онол нь хэд хэдэн нийлмэл сувгуудыг санал болгодог, Илүү монетарист хандлагаар Браун (Browne) (1984)-нь шилжилтийн сувгуудын хоорондох хамаарлыг үнэлэхийг оролдсон. Тэрээр SOE загвар дахь капиталын урсгалыг нэмэгдэхэд гадаадын мөнгө их үүрэгтэй байдгийг тогтоосон бөгөөд эцэстээ энэ нь инфляцийг бий болгодог гэжээ. Тэрээр дотоодын мөнгөний бодлого нь богино хугацаанд маш их нөлөөтэй байдгийг нотолсон бөгөөд 6 сарын дараагаас урт хугацаанд нөлөөлдөггүй гэдгийг няцааж чадаагүй. Браун (Browne)-ийн шилжилтийн тэгшитгэл нь экзоген буюу өндөр хамааралтай гэж хүлээсэн маш олон хувьсагчтай загвар

байв. Ерөнхийдөө капиталын урсгал шилжилтийн суваг нь урсгал капиталын сувгаас тусдаа тодорхойлогдож чадахгүй юм.

Хэйкетт (Haekett), Хонохэн (Honohan) (1981) нар зардлын инфляцийн болон чанарын эмпирик баталгааг гаргасан. Энэхүү эмпирик шинжилгээ нь Ирландын ХҮИ-ийн өөрчлөлтийн 75% нь хоцрогдолтой импортын үнэ болон цалингаар тайлбарлагддаг. Ирландын үнийн тэгшитгэлд цалин ач холбогдолтой байгаа нь ганцаараа дотоодын зардлын инфляцийн баталгаа болохгүй. Жижиг нээлттэй эдийн засагт цалин экзоген гэж таамаглах боломжгүй гэсэн дүгнэлт хийсэн.

Скандиновын хандлагаар Кассиди (Cassidy) (1982)-нь худалдааны болон худалдааны бус үнүүдийн хувьд тэгшитгэлийн дотоодын хувьсагчуудын хамаарлыг үнэлсэн. 1955-1972 оны өгөдлөөр судалсан бөгөөд тэрээр худалдааны болон худалдааны бус үнийн өөрчлөлтөнд Их Британи үнэ чухал үүрэгтэй гэдгийг харуулсан.

Мэллис (Mellis) (1993)-ийн шинжилгээ болон Линдбэк (Lindbeck) (1999)-ийн засварласнаар Ирландын худалдааны үнэ нь мөн худалдааны бус үнэтэй маш их хамааралтай гэдгийг гаргаж ирсэн. Эдгээр үр дүн нь Скандиновын загварын зарим гол таамаглалуудтай үргэлж нийцдэг. Кассиди (Cassidy)-н судалгааны нэг эргэлзээтэй шинж нь үнийн тэгшитгэлүүдийн детерминацийн коэффициент харьцангуй бага байсанд оршино. Дотоодын хувьсагчдын үүргийг гаргаж ирэхийг оролдсон бусад судалгаа нь монетарист хандлагатай холбоотой байдаг.

Жери (Geary) (1981) нь дотоодын мөнгөний бодлого нь статистикийн хувьд нөлөөтэй гэдгийг илрүүлсэн. Дотоодын мөнгөний нийлүүлэлт нь гадаад байдлаар тодорхойлогдсон дотоодын үнэнд бүтнээрээ эндоген байдлаар авч үзэгддэг. Гэсэн хэдий ч Браун (Browne) (1984)-ийн шинжилгээ тодорхой болгосноор дотоод мөнгөний нийлүүлэлтийн үүрэг нь эцэстээ урт хугацаанд нөлөөлөгч хүчин зүйлс нь гадаадынх байдаг шилжилтийн механизмын дараагийн шинжилгээг бүрдүүлж магадгүй юм. Төстэй чиглэлээр Хонохан (Honohan) (1982) нь эндоген хувьсагчдын хооронд хамаарал байх ба ингэснээрээ учир шалтгааныг тайлбарлах ёстой гэж тэмдэглэжээ. Гадаад инфляци зэрэг орхисон экзоген хувьсагчид нь 2 хувьсагчид нөлөөлдөг.

Дээр тэмдэглэснээр, шинэ мөнгөний онолын дагуу бодит болон боломжит валютын ханшийн өөрчлөлтүүдийн үүрэг нь инфляцийн шинжилгээнд багтах шаардлагатай юм. Валютын ханшийн ямар нэг байнгын өөрчлөлт нь дотоодын инфляцид тухай бүр нөлөөлдөг гэдгийг тэнцвэрийн байрлалаас SOE загвар нь харуулдаг.



Флинн (Flynn) (1986) 10 хувийн ханш бууралтын нөлөөллийг шинжилсэн симуляцидаа урт хугацаанд ханшийн бууралтаас өрсөлдөөний ашиг олох боломжгүй гэдгийг харуулсан. Тодорхой нөхцөлд импортын үнэ, экспортын үнэ, гарцын үнэ болон түүхий эд материалын үнүүдийн маш хурдан хариу үйлдэл хийгддэг. Ихэнх тохируулга нь дөрвөн улирлын дотор болдог. Гэхдээ цалин болон хэрэглээний үнийн бүрэн, гүйцэд тохируулга нь тус тусдаа 16-18 улирал зарцуулдаг. 1972-1984 онуудын өгөгдлийг ашиглаж импортын үнэ, хэрэглээний үнэ болон цалингийн тэгшитгэлүүдийг үнэлсэн Флинн (Flynn), Хонохан (Honohan) (1986) нарын ажил нь эдгээр үр дүнг баталсан. Хэрэглээний үнийн индексийн (ХҮИ)-ийн тэгшитгэлд ашигласан алдаа засварлалын загвар (ЕСМ)-нь цалин богино хугацаанд их нөлөөлтэй үед валютын ханш өөрчлөгдөөгүй байвал дотоодын үнэ нь гадаадын үнэтэй нийлэхээс сэрэмжлэх хэрэггүй гэдгийг илэрхийлдэг. Флинн (Flynn), Хонохан (Honohan) (1986) нар нь мөн шинэ валютын ханшийн дэглэмийн онолын шинжилгээг бий болгосон. Үнийн нэг удаагийн шок нь байнгын инфляцийг үүсгэх боломжтой бөгөөд энэ нөлөөлөл нь магадгүй валютын ханшийг тохируулах бодлого, хандлагыг илүү тохируулдаг.

О.Коннен (O.Connen), Фрайн (Frain) (1989) нар дээрх санаануудад сөргүүлэн валютын ханшийн өөрчлөлт магадгүй инфляцийн дотоодын түвшинд бүтнээрээ нөлөөлдөггүй гэдэг санааг дэвшүүлжээ. О. Коннен (O.Connen) болон Фрайн (Frain) нар 1973-1987 оны хооронд Ирландын тоон өгөгдлөөр Бруно (Bruno) (1979)-ийн загварын Хиниариос (Hiniarios) (1987)-ийн өөр нэг хувилбарыг хэрэглэсэн. Загварын тусдаа хоёр хувилбараар үнэлэхэд, үндсэн дүгнэлт нь валютын ханшийн өөрчлөлтийн зөвхөн 50% нь дотоодын үнэнд нөлөөлдөг гэж гарчээ. Энэ дүгнэлт нь хоцрогдолтой авч үзсэн валютын ханшийн коэффициентуудын нийлбэр нь ойроолцоогоор 0.5 байна гэсэн баримтанд үндэслэсэн. Энэ нь зөвхөн урт хугацааны гадаадын үнэ болон валютын ханш 2 эсвэл 3 хоцрогдолтой нөлөөтэй бол хүчинтэй юм. Валютын ханш олон хоцрогдлыг хэрэглэх үед 100% нөлөөлдөг гэсэн таамаглал няцаагдаж чадахгүй. Нэмж хэлэхэд О.Коннен (O.Connen), Фрайн (Frain) нарын хамаатай хувьсагчдын шинжилгээ нь 1-р эрэмбийн ялгавраар хийгддэг. Дээрх судалгааны үр дүнгүүдээс, Ирландын үнийн хүчин зүйлд валютын ханш шийдвэрлэх гол үүрэгтэй гэдэг нь харагдаж байна.

Коллэн (Callan), Фицджералд (Fitzgerald) (1989) нар Ирландын аж үйлдвэрийн секторын үнийн хүчин зүйлийг үнэлсэн. Коинтэгрэшн тестийн үндсэн дээр Ирланд болон Их Британи, Ирланд болон Германы үнийн хоорондох урт хугацааны тэнцвэрийн холбоо оршин байх таамаглалыг шалгасан. 1975-1987 оны үеийн өгөгдөлд Ирланд нь Их



Британи эсвэл Германтай тус тусдаа коинтэгрэшн биш юм гэсэн үр дүн гарсан. Гэхдээ Ирландын үнэ нь магадгүй Их Британи болон Германы хоёулангых нь жигнэсэн дундажтай коинтэгрэтэд байж болох юм гэж таамагласан. Иймээс Германы үнийн үүрэг нь EMS-ийн дараах дэглэмтэй үед маш их юм. Үүнийг Врайт (Wright) (1997), Конни (Konny) болон Мак Геттинган (Mc Gettingan) (1996) нар дэмжсэн байна.

О.Коннен (O.Connen), Фрайн (Frain) нар Ирландын ХҮИ-ийн инфляцийг тайлбарлахад дотоодын илүүдэл мөнгөний хэмжигдэхүүн чухал үүрэгтэй гэж үзэж байсан. Ер нь илүүдэл мөнгө нь зөвхөн богино хугацаанд тайлбарладаг гэдэг дээр маргаантай байдаг. VAR шинжилгээгээр Хаулэтт (Howlett), Мак Геттинган (Mc Gettigan) (1995) нар ирээдүйн Ирландын инфляцийг таамаглахад дотоодын мөнгөний нийлүүлэлтийн зарим үүргийг олж тогтоожээ.

Цалингийн өсөлт нь инфляцид нөлөөлөгч дотоод хүчин зүйлс гэдэг дээр анхаарал татсан хэвээр байна. Нээлтэй эдийн засгийн тодорхойлолтоор Коллэн (Callan), Фицджералд (Fitzgerald) (1989) нар үнийн хүчин зүйлийн хаалттай эдийн засгийн загвар дахь цалингийн үүргийг авч үзсэн. Гэхдээ урт хугацааны цалингийн нөлөөлөл нь аж үйлдвэрийн салбарын 2 хувийн үйлдвэрүүдэд ажиглагдсан. Өнөө үед Фантас (Fountas), Лайлли (Lally), Ву (Wu) (1995) нар инфляци болон цалингийн өсөлт хоорондын холбоог авч үзсэн Мера (1991)-ийн боловсруулсан үндсэн санааг ашиглан богино хугацаанд цалин нь үнэтэй Granger шалтгаантай байдгийг гаргаж ирсэн.

***Туркэд хийгдсэн инфляцийн эмпирик судалгаа.*** Акюз (Akyuz) (1973) Туркийн инфляцийн шалтгаан болон динамикийг судлах шинжилгээний анхны оролдлогыг хийсэн. Тэрээр 1950-1968 оны хооронд дасан зохицох хүлээлт-мөнгөний эрэлтийн холимог загварын томъёоллоор мөнгөний нийлүүлэлт болон үнийн хоорондох холбоог судлаад инфляци нь өөрөөсөө хамаардаггүй гэж дүгнэсэн ба энэ нь мөнгөний нийлүүлэлт, бодит орлого, мөн мөнгөний биш харьцааны одоо болон өнгөрсөн үе дэх өөрчлөлтөөр тайлбарлаж болно гэж дүгнэжээ.

Эртугкул (Ertugkul) (1982)-ийн дэлгэрэнгүй судалгаа нь 1980-аад оноос өмнөх мөнгө болон үнийн хоорондох учир шалтгааны статистик шинжилгээг хийсэн. Зохиогч нь 5 тэгшитгэлтэй, инфляци өөрөө нөлөөлдөг загварыг боловсруулсан. Тэрээр засгийн газрын алдагдлыг ХАА-н харьцангуй үнийн функцээр загварчилсан. Ertugkul-ийн макро эдийн засгийн систем загвар нь бодит орлогын өсөлт, үнийн ерөнхий түвшинд сөрөг нөлөөтэй байсныг харуулсан. Тэрээр тухайн инфляцийн гол нөлөөлөгч хүчин зүйл нь инфляцийн хүлээлтийн хувьсагч гэж дүгнэжээ.

Аксой (Aksoy) (1992) нь Туркийн өгөгдлийг ашиглан инфляцийн монетарист болон бүтцийн онолыг шалгах зорилготой байсан. Тэрээр мөнгөний нийлүүлэлт болон үнийн хоорондох холбоо нь пропорциональ биш боловч инфляцийн хүлээлт болон гадаадын валютын шинж чанараас хамаардаг гэж дүгнэжээ. Үүнээс гадна тэр харьцангуй үнийн зардлын нөлөө байгааг бага зэрэг гаргаж ирсэн.

Тоган (Togan) (1987) мөнгө болон зээлийн хүүгийн хугацааны цуваа нь 1960-1983 оны инфляцийн түвшний шилжилтээр тодорхойлогдож байна гэж дүгнэсэн. Онис Озмукур (Onis Ozmucur) (1990) судалгаагаараа нийлүүлэлтийн талын хүчин зүйлс инфляцид ерөнхийдөө чухал нөлөөтэй гэж таамаглаад Туркийн лирийн ханшийн бууралт нь дотоодын инфляцид хүчтэй нөлөөтэй байдгийг онцолжээ.

Риттенберг (Rittenberg) (1993) нь Гранжер шалтгааны тест нь үнийн өөрчлөлт валютын ханшийн өөрчлөлтийг бий болгож байгааг үзүүлсэн боловч эсрэг чиглэлд эргэх холбоо байхыг харуулсан.

Еэлдэн (Yeldan) (1993) нь ашиг/түрээсийн инфляци нь цалингийн инфляцитай харьцуулахад зардлын тал дээр хүчтэй инфляцийн нөлөөтэй байна гэдгийг ашигласан. Еэлдэн (Yeldan) туркийн аж үйлдвэрийн импортын хамааралтай байдалтай холбоотой импортын инфляцийн гол эх сурвалжаар валютын ханшийн бууралтын бодлогыг илүүд үзсэн.

Метин (Metin) (1995) нь судалгааныхаа үр дүнд илүүдэл мөнгөний эрэлт нь богино хугацаанд инфляцийг өсгөдөг гэсэн дүгнэлтийг хийсэн. Энэ нь инфляцийг амжилттай бууруулахын тулд засгийн газар төрийн секторын төсвийн алдагдлыг багасгах шаардлагатай гэсэн үг юм.

Инсел (Insel) (1995); Эрол (Erol), ван Вижнбергэн (van Wijnbergen) (1997); Лим (Lim), Папи (Papi) (1997); Агенор (Agenor), Хофмайстер (Hoffmaister) (1997), Даррат (Darrat) (1997), Акюрек (Akyurek) (1999) нар мөн ханшийн бууралт нь инфляцид нөлөөлдгийг судалгаагаараа харуулсан.

Олон судлаачдын дүгнэлт нь Туркийн инфляцийг бууруулахын тулд валютын ханшинд суурилсан тогтворжилтын хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай гэдгийг илэрхийлж байна. Валютын ханшийн тогтворгүй байдал болон инфляцийн түвшнийг сейнорайж (seigniorage) дэх үндэсний мөнгөн тэмдэгтийн орлуулалтын нөлөөллөөр эмпирик байдлаар Селкук (Selcuk) (1994, 1997 болон 2001), Скасциавиллани (Scacciavillani), Акэй (Akcaу) (1995); Алпер (Alper), Карасула (Karasulu) (1997) нараар судлагдсан. Селкук (Selcuk) (2001) эдийн засагт мөнгөн тэмдэгт орлуулалтын өндөр зэрэгтэй байх тусам туркийн засгийн газар

нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэх сейнорайж (seigniorage) орлогыг илүү их цуглуулж чадахгүй гэжээ.

Одоогоор Акка (Akca), Алпер (Alper), Озмукур (Ozmucur) (1997); Лим (Lim), Папи (Papi) (1997); Агенор (Agenor), Хоффмайстэр (Hoffmaister) (1997); Алпер (Alper), Юсер (Ucer) (1998); Акюрек (Akyurek) (1999), Сизер-Сакалиогли (Cizre-Sakaliogli), Еэлдэн (Yeldan) (1999); Баум (Baum) (1999) нар туркийн инфляцийн үйл явц дахь инерцийн үүргийг өсөж байгааг онцлон тэмдэглэсэн. Инфляцийн инерцийн хүлээлтийн бүрэлдэхүүн хэсэг нь засгийн газрын бодлогын итгэл муутай байдлаас болдог байх талтай.

***Хөгжиж байгаа зарим орнуудад инфляцийн судлагдсан байдал.***

Дуреволл (Durevall) Ндангу (Ndung'u) (2001) нар 1974-1996 онуудын Кенийн инфляцийн динамикийг судлахдаа алдаа засварлалын загварыг (Error-Correction model) ашигласан. Тэд мөнгөний хүчин зүйлүүд болон хүнсний нийлүүлэлтийн хязгаарлалтууд нь богино хугацаанд инфляцид хүчтэй нөлөөтэй, харин урт хугацаанд гадаад хүчин зүйлүүд зохих нөлөөтэй гэж дүгнэжээ.

Хан (Khan), Шиммелфеннинг (Schimmelpfennig) (2006) нар Пакистаны инфляцийг тайлбарлахдаа нийлүүлэлтийн талын хязгаарлалтуудыг төлөөлүүлэн улаан буудайн үнийг ашиглан монетарист болон бүтцийн загварыг холимог байдлаар судалсан.

Траоре (Traore), Жеуди (Jeudy), Блэйн (Blein) (2003) нар 2001-2002 оны ган гачиг болсон Мали, Буркани болон Нигер улсуудын гурил, будааны үнийн огцом өсөлтийг тодорхойлогч хүчин зүйлүүдийг илрүүлсэн. Малигийн хувьд бол ижил хүчин зүйлүүд гурил, будааны үйлдвэрлэл болон үнэнд нөлөөлж байсныг тогтоосон. Жуселиус (Juselius) (1991), Начега (Nacheга) (2001), Дуреволл (Durevall) Ндангу (Ndung'u) (2001) нарын үр дүнгээс бид урт хугацаанд мөнгөний зах зээл болон гадаад зах зээлийн тэнцвэргүй байдлаас инфляци бий болдог гэж таамагласан. Эдгээр судлаач нар зах зээл бүрийн тэнцвэрийн холбоог тус тусад нь судалсан

Малигийн инфляцийн шийдвэрийн макро эдийн засгийн цувааны хоорондох эдгээр холбоонууд, нийлүүлэлтийн талын хязгаарлалтууд болон богино хугацааны тохиргоонуудаас хазайх хазайлтуудын харьцангуй чухал байдлыг үнэлсэн.

Нийлүүлэлтийн талын хязгаарлалтуудыг төлөөлүүлэн будаа, гурилын бүтээгдэхүүнийг ашигласан.

### 2.3 МОНГОЛЫН ИНФЛЯЦИЙН НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ЭМПИРИК СУДАЛГАА

Монгол банк (МБ)-ны судалгааны хэлтсийн (СХ) эдийн засагч Л.Даваажаргал (2002, 2005) суурь инфляцийг хасаж зохицуулах арга, тэгшитгэж зохицуулах арга, статистик арга гэсэн энгийн гурван аргаар тооцжээ. Суурь инфляцийг нийлүүлэлтийн шоктой холбоотой үнийн өөрчлөлтийн нийт үнийн түвшинд нөлөөлөх нөлөөллийг хасаж тодорхойлдог. Хэрэв нийлүүлэлтийн сөрөг шок нь байнгын шинжтэй байвал үнийн түвшинг эргэлт буцалтгүй нэмэгдүүлэх боловч инфляцийн нөлөөлөл нь түр зуурын шинжтэй байна. Гэхдээ байнгын шинжтэй нийлүүлэлтийн шок нь инфляцийн хүлээлтийг өсгөх магадлалтай юм. Судалгааны үр дүнд статистик аргаар тооцсон суурь инфляци улирлын зохицуулалт сайн хийдэг бөгөөд нийлүүлэлтийн талын шокийн нөлөөллийн ихэнхийг инфляциас цэвэрлэж байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

Монгол банкны СХ-ийн эдийн засагч А.Хулан (2005) “Инфляцид нөлөөлж буй зарим хүчин зүйлс” судалгааны ажлын гол зорилго нь манай улсын инфляцид нөлөөлж буй хүчин зүйлсийг хэд хэдэн аргаар тодорхойлохыг зорьжээ. Үүнд, инфляцийг түүний ерөнхий хандлага болон мөчлөгүүдэд задлах аргачлал, хувьсагчдын харилцан үйлчлэлийн чиг буюу учир шалтгаант холбоог тодорхойлох Гранжерийн тест болон Филипсийн муруйн үнэлгээний аргуудыг ашиглажээ. Онолын хувьд инфляцид нөлөөлөгч макро хүчин зүйлсүүдэд бодит үйлдвэрлэлийн зөрүү (output gap), төсвийн алдагдал, мөнгөний нийлүүлэлт, импортын цар хүрээ, гадаад худалдааны тэнцэл, ханшийн өөрчлөлт зэрэг ордог бөгөөд эдгээр нь манай инфляцид нөлөөлөх сувгийг тодорхойлохыг зорилт болголоо. Ийнхүү Филипсийн муруйн шинжилгээний үр дүнгээр М2-мөнгөний нийлүүлэлт, инфляцийн өмнөх үеийн утга, нийлүүлэлтийн шок, улирлын хэлбэлзэл зэрэг нь инфляцид онолын таамаглалтай адил нөлөөлж байсан бөгөөд харин үйлдвэрлэлийн зөрүү (output gap) нь Гранжер шалтгааны тест болон Филипсийн муруйн шинжилгээгээр нөлөөлдөггүй болох нь батлагдсан.

Монгол Банкны мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч Н. Ургамалсүвд (2004) “2004-2005 оны инфляцийн таамаглалын талаар” судалгаагаараа инфляцийн таамаглалыг хийхдээ олон төрлийн загваруудыг ашигладагас энд өөрийн орны онцлог болон тоон мэдээллийн боломжийг харгалзан жигдрүүлэлтийн арга, динамик эгнээний нэг хувьсагчийн загвар-ARMA, Филипсийн муруй гэсэн 3 төрлийн загварыг сонгон ашигласан байна. Судалгааны үр дүнд экспоненциал жигдрүүлэлтийн арга, ARMA загвар, Филипсийн муруйгаар хийсэн 2005 оны прогноз нь харгалзан 12%, 7%, 4.3% байна гэж гарчээ. Инфляцийг прогнозлохдоо энд зөвхөн нэг

тэгшитгэлт загваруудыг ашигласан бөгөөд энэ нь инфляцид гадаад болон дотоод хүчин зүйлсийн дамжин нөлөөлөх нөлөөллийг авч үзээгүй байна.

Монгол банкны судалгааны хэлтсийн ахлах эдийн засагч Л.Даваажаргал “Импортын татвар инфляцид нөлөөлсөн үү?” судалгааны ажлаараа 1999, 2001 онуудад 5, 7%-аар импортын татварыг нэмсэн нь дотоодын инфляцид нөлөөлсөн эсэхийг тодруулах зорилготой байсан. Үнэлгээний үр дүнд инфляци нь гадаадын инфляциас маш хүчтэй хамааралтай буюу гадаадын инфляци 1%-аар өсөхөд дотоодын инфляци 0.89 %-аар өсөх, харин дотоодын мөнгөний нийлүүлэлтээс сул хамааралтай байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

МБСГ-ын захирал Б.Энххуяг (2001) “Монгол дахь инфляцийн эконометрик загвар” судалгаагаараа мөнгөний нийлүүлэлт, ханш нь инфляцид нөлөөлдөг эсэхийг тогтоохыг зорьжээ. Ингэхдээ ХБК (Ordinary Least Squares) аргыг ашиглан тогтоосон. Үүний үр дүнд 12 сарын хоцролттой мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлт ХҮИ-г нөлөөлдөг болох нь тогтоогдсон, харин үүнээс цааш хугацаанд тогтоож чадаагүй.

МБ-ны эдийн засагч Н.Ургамалсүвд (2002) “Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн уялдаа” судалгааны хүрээнд инфляцийн түвшин ба мөнгөний нийлүүлэлтийн хооронд ямар нэг хамаарал байгааг эсэхийг энэ төрлийн шинжилгээнд хамгийн өргөн хэрэглэдэг ко-интэгрэйшн анализыг ашиглан шалгасан. Судалгаанд хамрагдсан үзүүлэлтүүдийн хооронд дөрвөн боломжит урт хугацааны шугаман хамаарал байж болохыг Johansen тестийн үр дүнгээс харж болно.

Д.Ган-Очир, Г.Борхүү нар “Инфляци болон мөнгөний үзүүлэлтүүдийн хамаарал” судалгаандаа ARIMA, VAR загваруудыг ашиглан инфляцид мөнгөний агрегатууд болон валютын ханш, төв банкны үнэт цаасны хүү, инфляцийн өмнөх үеийн утгууд нөлөөлж байгаа эсэхийг шалгахад бүгд нөлөөтэй байсан бөгөөд валютын ханш нь хүчтэй нөлөөтэй, харин мөнгөний нийлүүлэлт, төв банкны үнэт цаасны хүү сул нөлөөтэй байна гэсэн үр дүн хүрчээ.

МБ-ны судалгааны хэлтсийн эдийн засагч А.Хулан (2004) “Монгол улсын еврогоор хийсэн гадаад худалдаа инфляцид нөлөөлөх эсэх” судалгаагаар еврогийн ханшийн чангаралт нь еврогоор төлбөр хийгдсэн импортоор дамжин манай орны инфляци буюу үнийн өсөлтөд нөлөөлж буй эсэхийг тогтоохыг зорисон. Нийт хүнсний болон хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортод еврогийн төлбөрт бараа бүтээгдэхүүний эзлэх жин 8 хувиас хэтрэхгүй байна. Ийм учраас одоогийн байдлаар монгол улсын нийт импортын 10 хүрэхгүй хувийг эзлэх еврогоор төлбөр

хийгдсэн бараа бүтээгдэхүүний үнэ нь зах зээлийн үнэд нөлөөлөх замаар инфляцид нөлөөлөхгүй байгаа нь 2000-2004 оны мэдээнд суурилсан корреляцийн шинжилгээнээс харагдаж байна гэж дүгнэсэн байна.

МБ-ны Мөнгөний Бодлогын Хэлтсийн эдийн засагч Д.Ган-Очир (2005) “Цалин болон орлого, инфляци хоорондын уялдаа” судалгааны хүрээнд Төрийн албан хаагчдын цалин өсөх нь инфляцийг өсгөх шалтгаан болдог уу, эсрэгээр нь инфляци өндөр байх нь цалин болон орлогыг өсгөх шаардлага бий болгож байна уу гэсэн асуултад хариу өгөх үүднээс энэхүү судалгааны ажлыг эконометрикийн коинтэгрэшн болон алдаа залруулах загварын үр дүнд суурилсан Гранжер шалтгааны шинжилгээгээр судалжээ. Судалгааны үр дүнд урт хугацаанд цалингийн 10%-ийн өсөлт нь 4.45%-ийн инфляцийг бий болгодог байна. Манай эдийн засагт цалингийн өсөлт нь нэг улирлын дараагаас инфляцийн шалтгаан болдог бол харин инфляци нь хоёр улирлын дараагаас цалингийн өсөлтийг далладаг буюу урт болон богино хугацаанд харилцан бие биенийхээ Гранжер шалтгаан болж байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

## БҮЛЭГ 3

### МОНГОЛЫН ИНФЛЯЦИ УЛИРЛАА ДАГАН ӨӨРЧЛӨГДДӨГ


Инфляци нь тухайн улс орны эдийн засгийн дотоод онцлог, гадаад эдийн засгаас хараат байдал, гадаад худалдааны нөхцөл, цаг улирлаас хамааран өөрчлөгддөг. Нэн ялангуяа дөрвөн улиралтай, өвөрмөц уламжлалт аж ахуйтай, гадаад зах зээлээс үлэмж хараат манай орны хувьд энэ шинж чанар илүүтэй ажиглагдах магадлалтай юм. Тиймээс судлаач миний бие эдгээр шинж чанар манай орны хувьд хэрхэн илэрдгийг тогтоох зорилгоор ХҮИ-ийн динамикийг хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгийг ялгах аргын тусламжтай нарийвчлан судалсан болно.

#### **3.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН ШИНЖИЛГЭЭ**

Шинжилгээнд манай улсын эдийн засаг харьцангуй тогтворжиж, зах зээлийн механизм тодорхой хэмжээнд үйлчилж эхэлсэн 1996 оны 1-р сараас 2007 оны 9-р сарын хэрэглээний үнийн индекс, сарын инфляцийн түвшинг ашиглав. Дээрх хугацаанд 1995 оны 12-р сарын 31-ний үнийг суурь болгосон хэрэглээний үнийн индексийн өсөлт ямар байсныг Зураг 2-т үзүүлэв.

1995 оны 12-р сарын 31-ний үнэтэй харьцуулахад 2007 оны 9-р сарын байдлаар хэрэглээний сагсны бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин 3.6 дахин өсчээ. Өөрөөр хэлбэл 12 жилийн дотор бараа, үйлчилгээний үнэ дундажаар 4 дахин өссөн байна. Энэхүү өсөлт нь тогтворжсон эдийн засагтай өндөр хөгжилтэй орнуудын инфляцийн түвшинтэй харьцуулахад өндөр боловч, тогтворгүй эдийн засагтай хөгжиж байгаа хийгээд шилжилтийн эдийн засагтай орнуудынхтай харьцуулахад доогуур үзүүлэлт юм. Энэ хугацаанд ХҮИ-ийн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсэг ямар бүтэцтэй байсныг бүрэлдэхүүн хэсгийг ялгах энгийн аргаар ангилан авч үзье.

Зураг 2. Хэрэглээний үнийн индекс, 1995.XII.31-100%




ХҮИ нь 1996-2000 оныг дуустал эрчимтэй өсөөд, 2001-2003 оны эцэс хүртэл өсөлтийн хурд нь харьцангуй удааширч, 2004 оноос дахин хурдтай өсөх хандлагатай болсон байна.

Манай орны цаг уурын эрс тэс уур амьсгал, эдийн засгийн бүтцийн онцлогоос хамааран макро эдийн засгийн ихэнх үзүүлэлт сар, улирлын нөлөөлөлтэй байдаг. Тиймээс ХҮИ ч тэдгээртэй адил байх ёстой гэсэн таамаглалын үндсэн дээр түүний сарын индексийг тооцон үзэхэд I-V сарын хооронд ХҮИ өсдөг байна. Энэ нь өвлийн саруудад манай орны хөдөө аж ахуй болон бусад олонхи салбарын үйлдвэрлэл зогсч, хаврын саруудад барааны хомсдол үүсдэгтэй холбоотой юм. Харин VI-X саруудад үндсэн үйлдвэрлэлүүд сэргэж, бүтээгдэхүүний нийлүүлэлт ихэссэн үнэ буурдаг бол XI-XII сард дахин өсдөг нь улирлын шинжтэй үйлдвэрлэл зогсохоос гадна уур, ус, дулаан, халаалтай холбоотой зардлууд ихэсдэгтэй хамааралтай байна (Зураг 3).

Мөн ХҮИ-д хийсэн бидний судалгаагаар 1996-1997 оны дунд үе, 1999-2001 он, 2003-2005 оны хагас жил хүртэлх хугацаанд мөчлөгийн өсөлтийн үе ажиглагдсан бол 1997 оны дундаас 1999 он, 2001-2003 он, 2005 оны хагас жилээс 2006 оныг дуустал уналтын үе үргэлжилжээ. Харин 2007 оны эхнээс өсөлтийн үе дахин ажиглагдах болсон байна. Энэ нь манай улсын эдийн засгийн үйл ажиллагааны идэвхижилтэй, тухайлбал дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнэ өссөн хийгээд цаг агаарын байдал харьцангуй тааламжтай байсантай холбоотойгоор үүссэн “хөөрөлттэй” хамааралтай байж болох юм.



Зураг 3. ХҮИ-ийн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгүүд




Дотоодын эдийн засгийн онцлог, гадаад эдийн засгийн хараат байдал зэргээс шалтгаалан урьдчилан таагдахгүй гэнэтийн нөлөөллийн улмаас бараа, үйлчилгээний үнэ богино хугацаанд ихээхэн хэлбэлзэлтэй байдаг нь гэнэтийн өөрчлөлтийн нөлөөллийн бүрэлдэхүүн хэсгийн зураглалаас харагдаж байна. 1996-1997, 1999-2001 онуудад гэнэтийн өөрчлөлтийн нөлөөлөл ихтэй байсан нь суурь үнийн чөлөөлөлт, Азийн эдийн засгийн хямрал, дотоодын банкны системийн хямрал зэргээс шалтгаалсан байж болох юм.

### 3.2 САРЫН ИНФЛЯЦИЙН ТАРХАЛТ, ХЭЛБЭЛЗЛИЙН ЗААГИЙН ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт 1996-2007 оны 9-р сар хүртэлх хугацааны сарын инфляцийн түвшинг авч үзэн, түүний тархалтын хуулийг тогтоож, түүвэрт хамрагдсан үеийнтэй ижил эдийн засгийн нөхцөлтэй тохиолдолд сарын инфляцийн түвшний хэлбэлзэх заагийг тогтоохыг зорив. Өөрөөр хэлбэл нэг сарын дотор үнийн ерөнхий түвшин хамгийн их өслөө гэхэд хэд хүрэх боломжтой, үнэ хямдарлаа гэхэд ямар хэмжээнд буурах боломжтойг судаллаа. Тухайн хугацаанд сарын инфляцийн түвшин нь хамгийн ихдээ 1996 оны 9-р сард 11.6 хувь байсан бол, 1997 оны 8-р сард үнийн хамгийн


багадаа -7.3 хувийн дефляцтай<sup>14</sup> байжээ. Зургаас харахад сүүлийн жилүүдэд сарын инфляцийн түвшний хэлбэлзлийн далайц багассан байна.

Зураг 4. Сарын инфляцийн түвшний динамик



Сарын инфляцийг тархалтын хуулийг тогтоохдоо MATLAB 7.0 программаар, хамгийн их үнэний хувь бүхий аргыг ашиглав. Шинжилгээний үр дүнд сарын инфляцийн түвшин нь 0.98 дундажтай, 1.63 стандарттай алдаа бүхий 2.97 чөлөөний зэрэгтэй Стьюдентийн t тархалттай болох нь тогтоогдсон (Зураг 5)

Зураг 5. Сарын инфляцийн тархалтын нягтын функцийн график




<sup>14</sup> Дефляц гэдэг нь инфляцийн эсрэг үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл үнийн ерөнхий түвшин буурахыг дефляц гэдэг.

Тархалтын хуулийн параметруудийн тусламжтай сарын инфляцийн хэлбэлзлийн заагийг тогтооход (-2.22; 4.18) интервалд байх боломж 95 хувь, харин (-4.92; 6.88) завсарт байх нь 99 хувийн магадлалтай байна. Өөрөөр хэлбэл одоогоор байдлаар инфляци өслөө гэхэд жилийн инфляцийн түвшин хамгийн ихдээ 84 хувьд хүрч болох юм.

### 3.3 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙН ХУГАЦААНЫ ЦУВААНЫ ЭКОНОМЕТРИК ШИНЖИЛГЭЭ

Инфляцийн цаашдын хандлагыг тогтоох, мөн өмнөх зүйлд авч үзсэн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгийн задаргааг нягтлах зорилгоор эконометрик шинжилгээг хийв. Үүний үр дүнд хэрэглээний үнийн индексийн хугацааны цувааны загвар нь Хавсралт 3-д өгөгдсөн байдлаар тодорхойлогдов. Үнэлгээнээс ХҮИ-ийн чиг хандлага шугаман ба авторегрессив холимог трендтэй тодорхойлогддож байна (Зураг 6).

Зураг 6. Хэрэглээний үнийн индексийн чиг хандлага



Сар бүрийн нөлөөллийн хувьд 1-5 сарын хооронд ХҮИ өсч, харин 6-10 саруудад буураад, 11-12 саруудад дахин өсдөг нь хэрэглээний үнийн индексийн сарын нөлөөллийн индексстэй тохирч байна. Тодорхой сонгож авсан сарын ХҮИ-д түүний өмнөх сарын үнийн өсөлтийн инерц, мөн гэнэтийн өөрчлөлт нөлөөлдөг нь ARMA(1,1) процесс гэдгээс харагдаж байна. Энэ загварын ашиглан 2007 оны сүүлийн саруудад ямар байхыг таамаглав.

## Хүснэгт 3. Инфляцийн таамаглал

Он, сар	Инфляцийн түвшин	Прогнозын цэгэн үнэлгээ	95 хувийн дээд зааг
2006:12	6.0	10.5	17.7
2007:01	4.2	10.6	17.8
2007:02	5.4	10.7	17.9
2007:03	6.0	10.8	18
2007:04	5.2	10.8	18
2007:05	5.8	10.9	18.1
2007:06	6.5	11.1	18.3
2007:07	7.2	11.4	18.6
2007:08	11.3	11.8	19
2007:09	13.3	12.1	19.3
2007:10		12.2	19.4
2007:11		12.4	19.6
2007:12		12.5	19.7

*Эх сурвалж. Судлаачийн тооцоолол*

Хүснэгтээс харахад 2007 оны инфляцийн түвшин 20-иос доош хувьтай байна гэдэгт 95 хувь итгэлтэй байж болохоор байна.

## БҮЛЭГ 4

### Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийг шинжлэхүй

Энэ бүлэгт инфляцийн онол, бусад орнуудад хийгдсэн эмпирик судалгаануудын үр дүнгүүдэд үндэслэн манай орны инфляцид нөлөөлөх гол хүчин зүйлсийн динамикийг шинжлэв. Инфляцийн онолд тулгуурлан эрэлтийн инфляцийн шалтгаан болгож мөнгөний нийлүүлэлт, төсвийн байгууллагын ажиллагсдын цалингийн динамикийг, нийлүүлэлтийн инфляцийн хувьд бензиний үнэ, хөрш орнуудын инфляцийн түвшин, валютын ханшийг, бүтцийн инфляцийн хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний мөчлөгийн үзүүлэлтийг сонгон инфляцийн өсөлтийн шалтгааныг тайлбарлахыг зорилоо.

#### 4.1 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ МӨЧЛӨГИЙН ШИНЖИЛГЭЭ

Дотоодын нийт бүтээгдэхүүний /ДНБ/ мөчлөгтэй ажилгүйдлийн түвшин хамааралтай байдгийг А.Оукен тогтоосон байдаг. Тиймээс ажилгүйдлийн түвшний нөлөөллийг Филипсийн хуулийг ашиглан эдийн засгийн мөчлөгийн үзүүлэлтээр илэрхийлж болох юм. Манай улсын хувьд эдийн засгийн мөчлөг хэрхэн илэрч байсан, ямар хүчин зүйлс үүнд нөлөөлж байсныг шинжлэх шаардлагатай. Үүний тулд 1989-2006 оны ДНБ-ийг 2000 оны зэрэгцүүлсэн үнээр авч үзье.

Хүснэгт 4. Нэрлэсэн болон Бодит ДНБ-ий динамик, өсөлтийн хувь


Он	ДНБ, оны үнээр, сая төг	ДНБ, сая төг, 2000 оны үнээр	ДНБ-ий өсөлтийн хувь
1989	10.7	1049.1	
1990	10.5	1022.7	-2.5
1991	18.9	928.2	-9.2

Он	ДНБ, оны үнээр, сая төг	ДНБ, сая төг, 2000 оны үнээр	ДНБ-ий өсөлтийн хувь
1992	47.3	840.0	-9.5
1993	194.8	814.8	-3.0
1994	324.4	833.5	2.3
1995	550.3	886.1	6.3
1996	646.6	907.0	2.4
1997	832.6	943.2	4.0
1998	817.4	976.6	3.5
1999	925.3	1008.0	3.2
2000	1018.9	1018.6	1.1
2001	1115.6	1029.1	1.0
2002	1240.8	1070.7	4.0
2003	1479.7	1134.5	6.0
2004	1945.7	1256.8	10.8
2005	2524.3	1346.1	7.1
2006	3172.4	1459.0	8.4

Эх сурвалж. Монгол Улсын статистикийн эмхэтгэл 1989-2002, 2006

ДНБ-ий мөчлөг хандлагыг тогтоохын тулд бодит ДНБ-ий чиг хандлагыг шинжлэх шаардлагатай. Үүнийг тогтоохын тулд Ходрик-Прескотын шинжүүрийг ашиглав.

Зураг 7. Бодит ДНТ ба түүнийг чиг хандлага




Зургаас харахад 1990-93 онуудад мөчлөгийн уналтын үе тохиосон байна. Энэ үе нь манай орны шилжилтийн эхний жилүүд бөгөөд эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих явцад гарсан хямралын үе юм. Харин

1993 оноос эдийн засаг харьцангуй сэргэж эхэлсэн агаад түүнээс хойш манай эдийн засаг мөчлөгийг бага хэмжээний хоёр үеийг туулжээ. 1993-1999 онд өсөлтийн үе, харин 2000-2004 онд уналтын үетэй байгаад 2005 оноос дахин сэргэсэн байна.

Эдгээр үеүд нь манай эдийн засагт тохиолдсон улс төр, байгаль цаг уур, дэлхийн зах зээлийн тааламжтай нөхцөлүүдтэй холбоотой юм. Үүнийг манай эдийн засгийн голлох хоёр салбар хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлд нөлөөлөгч хүчин зүйлсээс хялбархан ажиглаж болно.

Зураг 8. Малын тоо толгой




1995-1999 онд байгаль цаг уурын таатай байдлаас малын тоо толгой өсч, улмаар хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн бол 2000-2002 онд ган, зуднаас шалтгаалан малын тоо толгой 10 орчим саяар хорогдсон байна. Харин 2003 оноос дахин өсчээ.

Өнгөт металлын дэлхийн зах зээлийн үнэ, ханш манай орны уул, уурхайн үйлдвэрлэлийн мөчлөгийг тодорхойлдог. 1998-2000 онд дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ тогтвортой байсан бол 2001-2003 онд буурч, 2004 оноос өсч эхэлсэн төдийгүй 2006-2007 онд огцом өсөлттэй байсан байна (Зураг 9).

Дээрх хоёр салбарын орлогын нөлөө нь үйлчилгээний салбарыг тэтгэн, эдийн засгийн үйл ажиллагааг бүхэлд нь эрчимжүүлжээ. Үүнээс шалтгаалан санхүүгийн зах зээлийн хүчтэй тэлэлт, зуучлал нэмэгдэж, эдийн засаг мөнгөжсөн байна. Салбаруудын өсөлт татварын орлогыг нэмэгдүүлж, нийгмийн олон халамжийн тэтгэлэгийг урамшуулж, бүхэлдээ эрэлтийн инфляци үүсэх шалтгаан болжээ.

Зураг 9. Зэсийн үнийн динамик



Авч үзэж буй хугацаанд мөчлөг нөлөөлөл хэр хүчтэй илэрснийг регрессийн шинжилгээгээр тогтоов. Бодит ДНБ-ий чиг хандлагын регрессийн загварын үнэлгээг хавсралт 4-д харуулав. Энэхүү үнэлгээний үр дүнд мөчлөгийн нөлөөллийн хэмжээг тооцсон үр дүнг дараахь хүснэгтэд үзүүлэв. Хүснэгтэд сөрөг тэмдэгтэй тоогоор илэрхийлэгдсэн нөлөөлөл нь мөчлөгийн уналттай үеийг, харин эерэг тэмдэгтэй тоогоор илэрхийлэгдсэн нь өсөлттэй үеийг тус, тус илэрхийлнэ.

Хүснэгт 5. БДНБ-ий мөчлөг нөлөөллийн динамик

Он	Мөчлөг нөлөөлөл, 2000 оны үнээр тэрбум төг
1989	30.6
1990	50.0
1991	-7.5
1992	-67.6
1993	-73.4
1994	-44.2
1995	10.1
1996	23.8
1997	44.1
1998	52.7
1999	50.5
2000	18.7



Он	Мөчлөг нөлөөлөл, 2000 оны үнээр тэрбум төг
2001	-22.0
2002	-40.5
2003	-45.5
2004	-0.9
2005	1.8
2006	19.4

#### 4.2. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН БҮТЦИЙН ШИНЖИЛГЭЭ


Мөнгөний нийлүүлэлтийг уламжлалт шинжилгээнд “их мөнгө” буюу M2-оор эсвэл “бага мөнгө” буюу M1-ээр төлөөлүүлэн авч үздэг. Манай орны хувьд өмнө хийгдсэн инфляцийн судалгаануудын хувьд инфляцид M1 мөнгөний агрегат илүү нөлөөтэй байдаг гэсэн дүгнэлт, мөн M1 болон M2 агрегатууд өндөр хамааралтай байгаа байдлаас бид шинжилгээнд зөвхөн M1 агрегатыг ашиглав. Мөнгөний нийлүүлэлт буюу M1 агрегатын хугацааны цувааны бүтэц ямар байсныг сонирхоё /Зураг 10/.

Зургаас харахад M1 мөнгөний хэмжээ нь авч үзэж буй хугацаанд өсөх чиг хандлагатай байсан ба сарын болон мөчлөг нөлөөллийг агуулсан байдал ажиглагдаж байна. M1 мөнгөний хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгүүдийг ялган тайлбарлая.

M1 мөнгөний чиг хандлагыг харахад ХҮИ-ийн чиг хандлагатай адил байна. Тиймээс ХҮИ-ийн буюу инфляцийн өсөлтийн ерөнхий чиг хандлага нь M1 мөнгөний нийлүүлэлтээр тодорхойлогддог байна. Сарын нөлөөллийн хувьд ХҮИ-ийнхээс ялгаатай байна. Тухайлбал 1-5 сард ХҮИ тасралтгүй өсдөг байхад M1 мөнгөний нийлүүлэлт 1-2-р сард буураад 3-8 сард өсдөг байна. ХҮИ 6-10 сар хүртэл буураад, 11-12 сард өсдөг байхад M1-ийн нийлүүлэлт 9-11 сард буураад 12-р сард өсдөг байна. Зуны саруудад бэлэн мөнгө, хугацаагүй хадгаламж, харилцахын хэмжээ өсч байгаа нь мөн л манай эдийн засгийн үйлдвэрлэл, салбарын бүтцийн онцлогтой холбоотой байна.

Мөчлөг нөлөөллийн хувьд ихэнх хугацаанд ХҮИ-ийн мөчлөгийн эсрэг байсан нь мөнгөний бодлогын зохицуулалт, Монголбанкнаас хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын хувилбаруудтай холбоотой юм. Гэвч 2006 оноос мөчлөгийг дагасан үр дүн гарчээ.

Зураг 10. M1 мөнгөний динамик, түүний бүрэлдэхүүн хэсгүүд



### 4.3. ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАГСДЫН ЦАЛИНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Манай улсын практикт төсөвт байгууллагын ажиллагсдын цалинг нэмэхэд үнэ хөөрөгдөн өсгөдөг, мөн хувийн хэвшлийнхэн ажилчиддаа алдахгүйн тулд дагаж цалингаа өсгөн, тэрхүү өсөлтөө зардалдаа шингээн зардлын инфляци болж байгаа үзэгдэл илэрдэг. Тиймээс төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн өсөлт инфляцид ихээхэн нөлөөтэй байж болох юм. Сүүлийн жилүүдэд төсөвт байгууллагын ажиллагсдын цалин хэрхэн өссөн талаархи мэдээллийг төсвийн дундаж цалингийн мэдээллэлд тулгуурлан шинжилье. Энэхүү цалингийн өсөлт нь тухайн жилдээ бодит худалдан авах чадварт хэрхэн нөлөөлж байсныг авч үзье (Хүснэгт 6).

1995 оноос хойш төсөвт байгууллагын ажиллагсдын нэмсэн цалин нь худалдан авах чадварын хувьд хамгийн багадаа 1.2 хувиас дээд тал нь 22 хувь хүртэл өсчээ. Өөрөөр хэлбэл цалингийн өсөлт нь үнийн өсөлтийг давж байсан байна. Цалингийн бодит өсөлтөөс харахад төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн өсөлт инфляцийг өсгөсөн байх үндэслэлтэй харагдаж байна. Учир нь цалингийн өсөлтийн хувь өндөр

## Хүснэгт 6. Төсөвт байгууллагын ажиллагсдын дундаж цалин, түүний динамик

Он	Төсөвт, байгууллагын дундаж цалин, мян.төг	Хэрэглээний үнийн индекс, 1995-100	Бодит цалин, мян. төг, 1995 он суурь	Төсөвт байгууллагын дундаж цалингийн өсөлтийн хувь	Инфляц	Цалингийн бодит өсөлт
1995	14.7	100	14.7			
1996	21.6	144.6	14.9	46.9	44.6	2.4
1997	27.3	174.2	15.7	26.4	20.5	5.9
1998	34.5	184.7	18.7	26.4	6.0	20.4
1999	39.5	203.1	19.5	14.5	10.0	4.5
2000	51.3	219.6	23.4	29.9	8.1	21.8
2001	56.0	237.1	23.6	9.2	8.0	1.2
2002	60.5	241.2	25.1	8.0	1.7	6.3
2003	71.4	252.5	28.3	18.0	4.7	13.3
2004	85.9	280.2	30.7	20.3	11.0	9.3
2005	96.9	306.8	31.6	12.8	9.5	3.3
2006	124.0	325.1	38.1	28.0	6.0	22.0

Эх сурвалж. Хөдөлмөр Нийгмийн хамгааллын яам


байсан жилүүдэд инфляци илүү байсан тохиолдол ихэнх жилүүдэд ажиглагдаж байна.

#### 4.4 АМЕРИК ДОЛЛАРЫН ТӨГРӨГТЭЙ ХАРЬЦАХ ХАНШИЙН ШИНЖИЛГЭЭ

Америк долларын төгрөгтэй харьцаж буй ханш 1996 оноос 2007 оныг хүртэл 2.5 дахин өсчээ. 2000 оныг хүртэлх ханш хурдтай өсч байгаад харин сүүлийн жилүүдэд өсөлтийн хурд нь харьцангуй тогтвортой болсон байна. Чиг хандлагын хувьд эхний жилүүдэд ХҮИ-ийн чиг хандлагатай тохирч байсан боловч, сүүлийн жилүүдийн хурдацтай өсөлтийн хандлагатай тэр бүр таарахгүй байна (Зураг 11).

Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн хувьд сарын индексийг тооцож үзэхэд оны эхний гурван сард өсөх хандлагатай байдаг бол 4, 5-р сард буурдаг байна. Энэ нь хаврын сарын эхээр уул уурхайн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний нийлүүлэлттэй холбоотой

Зураг 11. Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн динамик




гадаад валют их хэмжээгээр нийлүүлэгддэгтэй холбоотой юм. Харин зуны саруудад бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн идэвхижилтэй үед бараа, түүхий эд, шатаж тослох материал, техник тоног төхөөрөмжийн импорт ихэсдэгтэй холбоотой цаашид өсөөд, харин 12-р сард бага зэрэг буурдаг тал ажиглагдаж байна.

Мөчлөгийн хувьд ХҮИ-ийн мөчлөгтэй бараг тохирч байгаа боловч, 2003 оныг хүртэл хугацааны бага зэргийн хожимдол илэрч байна. Харин 2004 оноос мөчлөг нь бараг нийцсэн байдал ажиглагдаж байна.

#### 4.5 БЕНЗИНИЙ ҮНИЙН ШИНЖИЛГЭЭ

Шинжилгээнд А93 бензиний үнийн индексийн 2000 оноос хойших мэдээллийг ашиглав. Мэдээллээс харахад 2003 оноос бензиний үнэ огцом өсч эхэлсэн байна. 2000 оноос одоог хүртэл бензиний үнэ 2.5 дахин өсчээ.

Зураг 12. А93 бензинийн үнийн индексийн динамик



А93 бензиний үнийн индекс нь ХҮИ-ийн сарын индекстэй бараг эсрэг динамиктай байдаг байна. Энэ нь бензиний эрэлтийн ихэсэлт үйлдвэрлэлийн идэвхитэй үетэй давхцдагтай холбоотой байж болох юм.

#### 4.6 ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

Гадаад худалдааны тэнцэл 2005 оныг хүртэл зарим саруудыг эс тооцвол байнга алдагдалтай байсан бол алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан сүүлийн 2-3 жилд ихэнх саруудад эерэг үлдэгдэлтэй болжээ. Энэ нь уул уурхайн компаниудын ашгийг ихэсгэн, ажиллагсдын дундаж цалин өсөх хандлагыг бий болгосон төдийгүй, орлогын хуваарилалтын үр дүнд үйлчилгээний салбарын үнэ өсөхөд хүрсэн байх талтай юм.

Зураг 13. Гадаад худалдааны тэнцэл, 1999-2007



Гадаад худалдааны сарын индексийн судалгаанаас харахад манай орны хувьд VI-XI саруудад худалдааны алдагдал багасч, харин үлдсэн саруудад ихэсдэг байна. Энэ нь мөн л үйлдвэрлэлийн салбаруудын үйл ажиллагаа улирлын шинжтэй байдагтай холбоотой юм. Гадаад худалдааны ашиг, алдагдал нь валютын ханшийн динамикт хүчтэй нөлөөлдөг байх талтай. Сарын индексийн ерөнхий хандлага нь америк долларын ханшийн сарын индекстэй нягт хамааралтай байна.

#### 4.7 ХӨРШ ОРНУУДЫН ИНФЛЯЦИ

Манай улсын хэрэглээний бүтээгдэхүүний ихэнх нь хоёр хөрш орноос импортолсон бүтээгдэхүүн байдаг. Импортын бүтээгдэхүүний хувьд дотоодын зах зээлд үнэ өсөх хэд, хэдэн шалтгаанууд байдаг. Үүнд:

- Дотоодын валютын ханш сулрах буюу гадаад валютын ханш чангарах
- Худалдааны хөрш орнуудын үнэ өсөх
- Гаалийн татвар нэмэгдэх
- Тээвэрлэлтийн зардал нэмэгдэх

Эдгээрээс гадаад валютын ханшийн чангаралтын нөлөөг америк долларын төгрөгтэй харьцах ханшийн өсөлтөөр төлөөлүүлэн судалсан. Хоёрдахь шалтгааныг шалгах зорилгоор худалдааны гол түнш орон болох ОХУ, БНХАУ-ын ХҮИ-ийн сарын өөрчлөлтийг авч үзэв. 2002 оноос хойш хөрш орнуудын ХҮИ-тэй манай орны ХҮИ хэр хамааралтай байсныг корреляцийн шинжилгээгээр тогтооё.

Хүснэгт 7. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын ХҮИ-ийн корреляцийн матриц


	Монголын ХҮИ	ОХУ-ын ХҮИ	БНХАУ-ын ХҮИ
Монгол Улсын ХҮИ	1.0	0.95	0.74
ОХУ-ын ХҮИ	0.95	1.0	0.73
БНХАУ-ын ХҮИ	0.74	0.73	1.0

Корреляцийн шинжилгээнээс манай орны инфляцийн түвшин нь худалдааны гол түншүүд болох хоёр хөрш орныхоо инфляцийн түвшинтэй хүчтэй хамааралтай байдаг нь тогтоогдов. Өөрөөр хэлбэл, худалдааны хөршүүдийн инфляци импортлогддог гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна (Зураг 14).


ОХУ-ын хувьд 2000 оноос 2007 оны 9-р сарын байдлаар үнийн ерөнхий түвшин 2.5 дахин өссөн байна. ХҮИ-ийн нь сарын индексийн динамик өөрчлөлтийг судлан үзэхэд манай улсын ХҮИ-ийн сарын индексийн хандлагатай яг тохирч байна. Энэ нь манай хоёр орны байгаль цаг уурын нөхцөлөөс хамаарсан үйлдвэрлэлийн процесстой холбоотой юм.

Өргөн хэрэглээний барааны импортын гол түнш БНХАУ-ын хувьд 2003-2005 онд үнэ хурдтай өсч байгаад 2006 оны турш буурч байсан бол 2007 оны эхнээс дахин өсөх болсон нь манай улсын инфляцид нөлөөлсөн байх талтай байна.

Зураг 14. ОХУ-ын Хэрэглээний үнийн индекс



Зураг 15. БНХАУ-ын Хэрэглээний үнийн индекс







## БҮЛЭГ 5

### Монголын инфляцийн өсөлтөд мөнгөнийхөөс илүүтэй мөнгөний бус хүчин зүйлс нөлөөлдөг

#### 5.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС БА БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ХУГАЦААНЫ ЦУВААНЫ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХАМААРАЛ

Өмнөх бүлгийн шинжилгээний авагдсан үзүүлэлтүүдийн хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгүүд нь хоорондоо ямар хамааралтайг корреляцийн шинжилгээгээр тогтоов.

Хүснэгт 8. ХҮИ ба түүнд нөлөөлөгч үзүүлэлтүүдийн корреляц хамаарал

Хугацааны цувааны бүрэлдэхүүн хэсгүүд	M1 мөнгө	Төсөвт байгууллагын ажиллагс-дын цалин	A93 бензиний үнэ	Америк долларын ханш	ДНБ-ий зөрүү	Худалдааны тэнцэл
Чиг хандлага	0.96	0.96	0.97	0.89		0.57
Сарын нөлөөлөл	0.36		-0.80	-0.55		-0.83
Мөчлөг нөлөөлөл	-0.42		0.62	0.49	0.27	0.65
Гэнэтийн өөрчлөлтийн нөлөөлөл	0.04		0.50	-0.08		0.13

ХҮИ-ийн өсөлтийн чиг хандлагад M1 мөнгө, төсөвт байгууллагад ажиллагсдын цалин, бензиний үнийн өсөлтийн чиг хандлагууд хамгийн ихээр нөлөөлдөг байна. Үнэ тасралтгүй өсч байгаад эрэлтийн болон нийлүүлэлтийн инфляцийн аль, алины нь шалтгаан хүчтэй нөлөөлж байна.

Харин сарын индексүүдийн хооронд тийм ч хүчтэй хамаарал оршин байхгүй байна. Тиймээс ХҮИ-ийн сарын индекс нь салбаруудын үйлдвэрлэлийн улирал сарын индекстэй илүү хүчтэй хамааралтай байх талтай. Бидний сонгосон үзүүлэлтүүдийн сарын индекс нь ХҮИ-ийн сарын индекстэй ихэвчлэн урвуу хамааралтай байна. Харин М1 мөнгөний нийлүүлэлтийн индекс сул эерэг хамааралтай байна. Хэрвээ хугацааны тодорхой хожимдлыг тооцвол хамаарал нь ихэсч болох юм. М1 мөнгөний сарын нөлөөлөл ХҮИ-д ойролцоогоор 2 сарын дараа нөлөөлдөг тал ажиглагдаж байна.

А93 бензиний үнийн болон худалдааны тэнцэлийн мөчлөг ХҮИ-ийн мөчлөгийг илүү тодорхойлж байна. Гэхдээ ДНБ-ий мөчлөг хандлага алгуур нөлөөтэй болох нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд америк долларын мөчлөг тодорхой хамааралтай болж эхэлсэн байна. Харин мөнгөний нийлүүлэлтийн мөчлөгүүд сул эсрэг нөлөөтэй байгаа нь бодлогын арга хэрэгсэл болдогтой холбоотой байх талтай.

Гэнэтийн өөрчлөлтийн нөлөөллийн хувьд ХҮИ-ийн гэнэтийн өөрчлөлтийн нөлөө нь А93 бензинтэй илүү хамааралтай байна. Өөрөөр хэлбэл бензиний үнэд гарсан шокууд ХҮИ-д илүү нөлөөлдөг зүй тогтолтой байна.

## 5.2 ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ИНТЕГРЕТЭДИЙН ЭРЭМБЭ

Инфляц, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн хамаарлын хуулийг тогтоохын тулд тэдгээр үзүүлэлтийн интегретэдийн эрэмбийг тогтоож, ко-интегрэшн үзүүлэлтүүдийн хооронд регрессийн шинжилгээг хийх шаардлагатай. Нэгж язгуурын шинжилгээгээр судалгаанд авагдсан үзүүлэлтүүдийн интегретэдийн эрэмбийг тогтоов. Үүнд:

### Хүснэгт 9. Үзүүлэлтүүдийн интегретэдийн зэрэг

Үзүүлэлтүүд	Интегретэдийн эрэмбэ
ХҮИ (CPI)	I(1)
М1 мөнгө (M1)	I(2)
Төсөвт байгууллагын ажиллагсдын цалин (WAGE)	I(2)
А93 бензиний үнийн индекс (A93)	I(1)
Америк долларын төгрөгтэй харьцах ханш (USD)	I(1)
Худалдааны тэнцэл (TB)	I(0)
ДНБ-ий мөчлөгийн үзүүлэлт (GAP)	I(0)

Энэ шинжилгээнээс ХҮИ нь М1 мөнгөний нийлүүлэлтийн болон төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн нэгдүгээр эрэмбийн ялгавраас буюу зэрэгцээ хоёр сарын өөрчлөлтийн зөрүүнээс, харин бусад үзүүлэлтийн түвшний утгаас хамаарахаар байна.

### 5.3 ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН УЧИР ШАЛТГААН, ҮР ДАГАВРЫН ХОЛБОО

Эдийн засгийн үзүүлэлтүүдийн нэг нь нөгөөгийнхөө учир шалтгаан, нөгөөх нь түүнийхээ үр дагавар болж байхад, зарим үзүүлэлтүүд нь харилцан бие биенийхээ учир шалтгаан болдог. Үүнийг Гранжерийн учир шалтгааны тестээр тогтоодог.

#### Хүснэгт 10. Үзүүлэлтүүдийн учир шалтгааны холбоо

##### Pairwise Granger Causality Tests

Date: 12/09/07 Time: 17:01

Sample: 2000:01 2007:09

Lags: 2

Null Hypothesis:	Obs	F-Statistic	Probability
D(M1) does not Granger Cause CPI	90	4.87708	0.00988
CPI does not Granger Cause D (M1)		2.58287	0.08148
D(WAGE) does not Granger Cause CPI	90	2.59244	0.08075
CPI does not Granger Cause D(WAGE)		2.09281	0.12965
A93 does not Granger Cause CPI	91	4.45518	0.01442
CPI does not Granger Cause A93		6.82973	0.00177
USD does not Granger Cause CPI	91	5.34761	0.00647
CPI does not Granger Cause USD		1.65060	0.19796

Бид шинжилгээнд үзүүлэлтүүдийн интегретэдийн эрэмбийг харгалзан учир шалтгааны хамаарлыг тогтоохыг зорисон болно. Шинжилгээнээс М1 мөнгөний нийлүүлэлт болон ХҮИ нь харилцан бие биенийхээ учир шалтгаан, үр дагавар болдог. Харин цалингийн өсөлт, америк долларын төгрөгтэй харьцах ханш нь ХҮИ-ийн учир шалтгаан болдог ба бензиний үнэ нь учир шалтгаан, үр дагавар нэгэн зэрэг байдаг гэсэн үр дүн гарч байна. Эдгээр дөрвөн 4 үзүүлэлт ХҮИ-ийн учир шалтгаан болох тул эдгээрийг ХҮИ-ийг тайлбарлагч үзүүлэлтээр сонгон авах бололцоотой юм.

#### 5.4 ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН СТАТИСТИК ХАМААРАЛ

Өмнөх зүйлүүдэд хийгдсэн статистик шинжилгээний үр дүнд тулгуурлан ХҮИ-ийн түвшний хувьд дараахь регрессийн олон хүчин зүйлийн шугаман загварыг тодорхойлж болохоор байна.

Регрессийн функцийн параметруудийн үнэлгээний утгаас харахад ХҮИ-ийн хувьд хугацааны нэг хожимдолтой дасан зохицох хүлээлт хийгддэг гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл хугацааны өмнөх үеийн инфляцийн практик түвшин, хүлээлтийн алдааны жигнэгдсэн дундаж утгаар хүлээлтийн утга тодорхойлогддог зүй тогтолтой бололтой.

M1 мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлтийн нэг хожимдолтой утга болон цалингийн өсөлтийн тухайн үеийн утгаас хамаардаг байна. Нэг үгээр хэлбэл M1 мөнгөний нийлүүлэлт 10 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд дараа сарын ХҮИ-ийн түвшинг 0.5 нэгжээр ихсэхээр байна (Хүснэгт 11).

Хүснэгт 11. ХҮИ ба тайлбарлагч үзүүлэлтүүдийн хамаарлын зүй тогтол

Хувьсагч	Коэффициент	t статистик
Тогтмол	-82.39	-3.10
CPI(-1)	1.02	11.50
CPI(-2)	-0.33	-3.85
D(M1(-1))	0.05	2.69
D(WAGE)	2.14	3.17
A93	0.13	3.08
USD(-3)	0.13	4.94
GAP	-0.44	-2.11
GAP(-2)	0.45	2.24
ТВ	-0.03	-1.99
MA(2)	0.72	9.4
Детерминацийн коэффициент	0.99	
Дарвин-Уатсоны статистик	1.87	
Фишерийн статистикийн утга	1038.8	

Харин цалинг 1000 төгрөгөөр нэмэгдэхэд ХҮИ тухайн сардаа 2.14 нэгжээр нэмэгддэг. А93 бензиний үнийн индекс 10 нэгжээр өсөхөд тухайн сарын харин америк долларын төгрөгтэй харьцах ханш 10 төгрөгөөр нэмэгдэхэд 3 сарын дараахь ХҮИ-ийг 1.3 нэгжээр өсдөг байна.

ДНБ-ий мөчлөг хэлбэлзэл урт хугацаанд бараг нөлөөлөлгүй боловч богино хугацаанд 2 сарын дараа ХҮИ-д эерэгээр нөлөөлдөг болно. Гадаад худалдааны тэнцэл 10 сая америк долларын алдагдалтай нөхцөлд тухайн сарын ХҮИ-ийг 0.3 нэгжээр нэмэгдэнэ.

ХҮИ-д 2 сарын өмнөх гэнэтийн тохиолдлын нөлөөлөл инерцээ хадгалан нөлөөлсөөр байдаг нь харагдаж байна. Судалгаанд авагдсан хүчин зүйлүүд ХҮИ-ийн өөрчлөлтийн 99 хувийн шалтгаан болно гэдгийг регрессийн загварын тайлбарлах чадвараас харж болно.

## 5.5 ХЭСГИЙН КОРРЕЛЯЦИЙН ШИНЖИЛГЭЭ

Хэсгийн корреляцийн коэффициентийн тусламжтай аль хүчин зүйл нь яг хэдэн хувийн нөлөөтэйг тогтоох боломжтой. Өөрөөр хэлбэл ХҮИ болон сонгон авсан үзүүлэлтээс бусад хүчин зүйлийн нөлөөг арилгасан нөхцөл дэх корреляц хамаарлыг тогтооно гэсэн үг. М1 мөнгөний нийлүүлэлтийн өсөлт ХҮИ-ийн өсөлтийн 20.6 хувийг, цалингийн өсөлт 29.3 хувийг, А93 бензиний үнэ 18.3 хувийг, америк долларын төгрөгтэй харьцах ханшийн өсөлт 7.2 хувийг, ДНБ-ий мөчлөг 3.4 хувийг, гадаад худалдааны алдагдал 11.4 хувийг тус, тус бүрдүүлдэг байна. Эндээс ХҮИ-д мөнгөний талын нөлөө 28 орчим хувь байгаа бол мөнгөний бус нөлөө 72 орчим хувийг эзлэж байна. Мөн ХҮИ-д эрэлтийн болон нийлүүлэлтийн талын шалтгаанууд тавь, тавин хувийн ижил нөлөөтэй байна.

### Хүснэгт 12. Хэсгийн корреляцийн шинжилгээний үр дүн

Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлс	Хэсгийн корреляцийн коэффициент
М1 мөнгөний өөрчлөлт	20.6
Цалингийн өөрчлөлт	29.3
А93 бензиний үнэ	18.3
Америк долларын төгрөгтэй харьцах ханш	7.2
ДНБ-ий мөчлөгийн үзүүлэлт	3.4
Худалдааны тэнцлийн эерэг үлдэгдэл	11.4

Дээрх байдлаас харахад инфляцийн эсрэг сангийн бодлогын арга хэрэгслүүдээр тэмцвэл илүү нөлөөтэй байх болно. Тухайлбал төсөвт байгууллагын ажиллагсдын цалинг дискрет өсгөх биш, тасралтгүйгээр тодорхой дүрмээр өсгөх, импортын гол нэрийн бараануудын хувьд гаалийн татварын хөнгөлөлт үзүүлэх, нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд татаас олгох, хөрөнгө оруулалтыг эдийн засгийн салбарын бүтцийг

улирлын нөлөөлөлгүй байнгын үйлдвэрлэлтэй болгоход чиглүүлэх, мөн экспортын бүтээгдэхүүнийг уул уурхай, хөдөө аж ахуйн анхдагч бүтээгдэхүүнээс аж үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн болгох, импортын орлох, эх орны бүтээгдэхүүний импортын орцыг багасгаж, дотоодын үйлдвэрлэлээр хангахад анхаарах шаардлагатай байна.

Мөн түүхий эд, материалын болон барааны бирж байгуулж, үйлдвэрийн газруудын хувьд түүхий эд, материалынхаа хувьд урт хугацаатай фуйчерс гэрээгээр үнэ тохирон, жилийн туршид бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахад анхаарах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 6

### Шинжилгээний нэгдсэн дүгнэлтүүд

1. Манай орны ХҮИ-ийн чиг хандлагаас харахад инфляци 1996-1999 онд эрчимтэй өсч байсан бол 2000-2003 онд өсөлтийн хурд нь саармагжаад, түүнээс хойш дахин хурдтай өсөх хандлагатай болжээ. Энэ ДНБ-ий мөчлөгийн үетэй тохирч байна. Инфляцийн чиг хандлага нь эдийн засгийн мөчлөгийн тогтсон үзэл баримтлалтай нийцэж байгаагаас инфляци өсч байгаагийн үндсэн шалтгааны нэг нь макроэдийн засгийн мөчлөгийн нөлөөлөл болж байна.
2. ХҮИ-ийн сарын нөлөөллийг тооцон үзэхэд I-V сарын хооронд ХҮИ өсдөг байна. Энэ нь өвлийн саруудад манай орны хөдөө аж ахуй, барилга болон бусад олонхи салбарын үйлдвэрлэл зогсч, хаврын саруудад барааны хомсдол үүсдэгтэй холбоотой юм. Харин VI-X саруудад үндсэн үйлдвэрлэлүүд сэргэж, бүтээгдэхүүний нийлүүлэлт ихэссэн үнэ буурдаг бол XI-XII сард дахин өсдөг нь улирлын шинжтэй үйлдвэрлэл зогсож, өвлийн барааны эрэлт нэмэгдэж, уур, ус, дулаан, халаалтай холбоотой зардлууд ихэсдэгтэй хамааралтай байна.
3. Шинжилгээний үр дүнд сарын инфляцийн түвшин нь 0.98 дундажтай, 1.63 стандартай алдаа бүхий 2.97 чөлөөний зэрэгтэй Стьюдентийн  $t$  тархалттай болох нь тогтоогдсон. Энэ нь жилийн ихэнх саруудад инфляцтай, цөөн хэдэн сард дефляцтай байдгийг илэрхийлж байна. Тархалтын хуулийн параметруудийн тусламжтай сарын инфляцийн хэлбэлзлийн заагийг тогтооход (-2.22; 4.18) интервалд байх боломж 95 хувь, харин (-4.92; 6.88) завсарт 99 хувийн магадлалтай оршин байна. Тиймээс одоогоор манай орны сарын инфляцийн түвшин маш их өслөө гэхэд 7 хувиас хэтрэхгүйгээр байхаар байна.
4. Хэрэглээний үнийн индексийн прогнозын эконометрик загварын үр дүнгээс харахад ХҮИ нь шугаман болон авторегрессив холимог чиг хандлагатай, өөрөөр хэлбэл чиг хандлага нь авч үзэж буй хугацаанд гурван удаа өөрчлөгдсөн, сарын нөлөөлөлтэй, нэг сарын өмнөх

түвшний утгын болон санамсаргүй хүчин зүйлсийн инерцийн нөлөөллийг агуулдаг нь батлагдав. Прогнозын үр дүнгээс харахад 2007 оны жилийн эцсээр хүлээгдэж буй инфляцийн дундаж түвшин 13 орчим хувь, хамгийн ихдээ 20 орчим хувийн инфляцтай байхаар тооцоо гарч байна.

5. ДНБ-ий мөчлөгийн шинжилгээнээс манай улсын макроэдийн засаг 1993-1999 онд мөчлөгийн өсөлтийн үетэй, харин 2000-2004 онд уналтын үетэй байгаад 2005 оноос дахин сэргэсэн байна. Эдгээр үеүүд нь манай эдийн засагт тохиолдсон улс төр, байгаль цаг уур, дэлхийн зах зээлийн тааламжтай нөхцөлүүдтэй холбоотой юм.
6. Мөнгөний нийлүүлэлтийн хувьд М1 мөнгөний нийлүүлэлтийн чиг хандлага нь ХҮИ-ийнхтэй тохирч байна. Тиймээс М1 мөнгөний нийлүүлэлт нь мөн л эдийн засгийн мөчлөгийн дагуу ерөнхийдөө дагаж өөрчлөгддөг байна. Харин М1 мөнгөний сарын нөлөөлөл, нэн ялангуяа мөчлөг нөлөөлөл нь ХҮИ-ийнхтэй тохирохгүй байгаа төдийгүй зарим тохиолдолд эсрэг байгаа тал ажиглагдаж байна. Энэ нь инфляцийн эсрэг хэрэглэсэн бодлогын чанартай арга хэмжээнээс шалтгаалсан байж болзошгүй.
7. 1995 оноос хойш төсөвт байгууллагын ажиллагсдын цалингийн өсөлт нь жил бүрийн инфляцийн түвшнээс их байсан нь цаашид бодит цалингаар дамжин инфляци өсөх шалтгаан болсон байх талтай юм.
8. Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн чиг хандлага нь ХҮИ-ийн сүүлийн жилүүдийн өсөлттэй тохирохгүй байна. Эхний жилүүдийн хувьд нилээд тохирч байсан тал ажиглагдаж байна. Энэ нь сүүлийн жилүүдэд гадаад валютын нөөц хангалттай болсонтой холбоотой болов уу.
9. Америк долларын төгрөгтэй харьцах ханшийн хувьд сарын индексийг тооцож үзэхэд оны эхний гурван сард өсөх хандлагатай байдаг бол 4,5 сард буурдаг байна. Энэ нь хаврын сарын эхээр уул уурхайн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрчимждэгээс гадаад валют их хэмжээгээр нийлүүлэгддэгтэй холбоотой юм. Харин зуны саруудад бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн идэвхижилтэй үед бараа, түүхий эд, шатаж тослох материал, техник тоног төхөөрөмжийн импорт ихэсдэгтэй холбоотой цаашид өсөөд, 12-р сард бага зэрэг буурдаг тал ажиглагдаж байна. Мөчлөг нөлөөллийн хувьд 2004 оноос мөчлөг нь ХҮИ-ийнхтэй бараг нийцсэн байдал ажиглагдаж байна.



10. Бензиний үнийн хувьд түүний чиг хандлага нь ХҮИ-ийг өсөхөд нөлөөлдөг бол А93 бензиний үнийн сарын индекс нь ХҮИ-ийн сарын индекстэй бараг эсрэг динамиктай байдаг байна. Энэ нь бензиний эрэлтийн ихэсэлт үйлдвэрлэлийн идэвхитэй үетэй давхцдагтай холбоотой байж болох юм.
11. Корреляцийн шинжилгээнээс манай орны инфляцийн түвшин нь худалдааны гол түншүүд болох хоёр хөрш орныхоо инфляцийн түвшинтэй хүчтэй хамааралтай байдаг байна. Өөрөөр хэлбэл, худалдааны хөршүүдийн инфляци импортлогддог байна.
12. ХҮИ-ийн өсөлтийн чиг хандлагад М1 мөнгө, төсөвт байгууллагад ажиллагсдын цалин, бензиний үнийн өсөлтийн чиг хандлагууд хамгийн ихээр нөлөөлдөг байна.
13. Сарын индексүүдийн хооронд тийм ч хүчтэй хамаарал оршин байхгүй байна. Тиймээс ХҮИ-ийн сарын индекс нь салбаруудын үйлдвэрлэлийн улирал сарын индекстэй илүү хүчтэй хамааралтай байх талтай. Бидний сонгосон үзүүлэлтүүдийн сарын индекс нь ХҮИ-ийн сарын индекстэй ихэвчлэн урвуу хамааралтай байна. Харин М1 мөнгөний нийлүүлэлтийн сарын индекс сул эерэг хамааралтай байна. Хэрвээ хугацааны тодорхой хожимдлыг тооцвол хамаарал нь сайжирч болох юм. М1 мөнгөний сарын нөлөөлөл ХҮИ-д ойролцоогоор 2 сарын дараа нөлөөлдөг тал ажиглагдаж байна.
14. А93 бензиний үнийн болон худалдааны тэнцэлийн мөчлөг ХҮИ-ийн мөчлөгийг илүү тодорхойлж байна. Гэхдээ ДНБ-ий мөчлөг хандлага алгуур нөлөөтэй болох нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд америк долларын мөчлөг ХҮИ-ийнхтэй тодорхой хамааралтай болж эхэлсэн байна. Харин мөнгөний нийлүүлэлтийн мөчлөгүүд сул сөрөг нөлөөтэй байгаа нь бодлогын арга хэрэгсэл болдогтой холбоотой байх талтай.
15. Гэнэтийн тохиолдлын нөлөөллийн хувьд ХҮИ-ийн нөлөө нь А93 бензинийхтэй илүү хамааралтай байна.
16. Учир шалтгааны шинжилгээнээс М1 мөнгөний нийлүүлэлт болон ХҮИ нь харилцан бие биенийхээ учир шалтгаан, үр дагавар болдог. Харин цалингийн өсөлт, америк долларын төгрөгтэй харьцах ханш нь ХҮИ-ийн учир шалтгаан болдог ба бензиний үнэ нь учир шалтгаан, үр дагавар нэгэн зэрэг байдаг гэсэн үр дүн гарч байна.
17. ХҮИ-ийн олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээнээс ХҮИ-ийн хувьд хугацааны нэг хожимдолтой дасан зохицох хүлээлт хийгддэг гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл хугацааны өмнөх үеийн инфляцийн практик түвшин, хүлээлтийн алдааны жигнэгдсэн дундаж

утгаар хүлээлтийн утга тодорхойлогддог зүй тогтолтой бололтой. М1 мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлтийн нэг хожимдолтой утга болон цалингийн өсөлтийн тухайн үеийн утгаас хамаардаг байна. Өөрөөр хэлбэл М1 мөнгөний нийлүүлэлт 10 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд дараа сарын ХҮИ-ийн түвшинг 0.5 нэгжээр ихэсэхээр байна. Харин цалинг 1000 төгрөгөөр нэмэхэд ХҮИ тухайн сардаа 2.14 нэгжээр нэмэгддэг. А93 бензиний үнийн индекс 10 нэгжээр өсөхөд тухайн сарын, харин америк долларын төгрөгтэй харьцах ханш 10 төгрөгөөр нэмэгдэхэд 3 сарын дараахь ХҮИ-ийг 1.3 нэгжээр өсдөг байна. ДНБ-ий мөчлөг хэлбэлзэл урт хугацаанд бараг нөлөөлөлгүй боловч богино хугацаанд 2 сарын дараа ХҮИ-д эерэгээр нөлөөлдөг болно. Гадаад худалдааны тэнцэл 10 сая америк долларын алдагдалтай нөхцөлд тухайн сарын ХҮИ-ийг 0.3 нэгжээр нэмэгдэнэ. ХҮИ нь 2 сарын өмнөх гэнэтийн тохиолдлын нөлөөг мэдэрдэг байна. Судалгаанд авагдсан хүчин зүйлүүд ХҮИ-ийн өөрчлөлтийн 99 хувийн шалтгаан болно гэдгийг регрессийн загварын тайлбарлах чадвараас харж болно.

18. Хэсгийн корреляцийн шинжилгээнээс М1 мөнгөний нийлүүлэлтийн өсөлт ХҮИ-ийн өсөлтийн 20.6 хувийг, цалингийн өсөлт 29.3 хувийг, А93 бензиний үнэ 18.3 хувийг, америк долларын төгрөгтэй харьцах ханшийн өсөлт 7.2 хувийг, ДНБ-ий мөчлөг 3.4 хувийг, гадаад худалдааны алдагдал 11.4 хувийг тус, тус бүрдүүлдэг байна. Эндээс ХҮИ-д мөнгөний талын нөлөө 28 орчим хувь байгаа бол мөнгөний бус нөлөө 52.4 орчим хувийг эзлэж байна. Үлдсэн 10 орчим хувь нь бидний регрессийн шинжилгээнд авч үзээгүй хөрш орнуудын үнийн өсөлт, эдийн засгийн салбаруудын өрсөлдөөний шинж чанараас хамаарах юм. Гэхдээ эдгээр орхигдсон үзүүлэлтүүд нь ч нийлүүлэлтийн талын буюу мөнгөний бус хүчин зүйлс болно. Инфляцид нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээгээр авч үзсэн эрэлтийн болон нийлүүлэлтийн хүчин зүйлс нь тавь, тавин хувийн нөлөөтэй байна. Үүнээс манай орны инфляцийн эсрэг бодлого нь сангийн бодлогод тулгуурлах нь илүү зохистой юм гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

## БҮЛЭГ 7

### ИНФЛЯЦИЙН ЭСРЭГ БОДЛОГЫН ХУВИЛБАР, ЗӨВЛӨМЖ

ХҮИ-ийн ерөнхий чиг хандлага нь хэдийгээр бидний сонгож авсан бодлогын болон нөлөөлөгч хувьсагчдын чиг хандлагаар тодорхойлогдож байгаа ч эдгээр бодлогын хувьсагчдын хандлага нь макроэдийн засгийн мөчлөгтэй нягт холбоотой байна. Манай улсын макроэдийн засгийн мөчлөг нь эдийн засгийн салбаруудын онцлог, дэлхийн зах зээл болон байгалиас хараат байдлаар тодорхойлогддог.

Мөн богино хугацааны хэлбэлзэл болох сар, улирлын өөрчлөлтүүд нь манай орны эдийн засгийн салбарын бүтэцтэй хамааралтай юм. Мөчлөг нөлөөлөл нь худалдааны тэнцэлээр илүүтэй илэрхийлэгдэж байгаа бол гэнэтийн тохиолдлын хэлбэлзэл нь бензиний үнэ, худалдааны хараат байдал, гадаад эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтай байна.

Энэ бүгдээс дүгнэхэд манай орны нөхцөлд инфляцийн эсрэг бодлого нь урт хугацааг хамарсан эдийн засгийн цогц бодлого байх шаардлагатай байна. Инфляцийг урт хугацаанд тууштай бууруулах ын тулд эдийн засгийн салбарын бүтцийг өөрчилж байгаль, цаг уур, дэлхийн зах зээл болон гадаад улс орнуудаас хараат байдлаа бууруулах шаардлагатай байна.

Судлаачийн зүгээс инфляцийн эсрэг богино, дунд, урт хугацаанд хоорондоо нягт холбоотой, харилцан уялдаатай бодлогын хувилбар гаргах хэрэгтэй гэж үзэж байна.

#### **7.1 БОГИНО ХУГАЦААНЫ БОДЛОГО**

Богино хугацааны бодлогын зорилго нь *“Тухайн үеийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн үнийн өсөлтөнд хариу үйлдэл хийхэд чиглэгдсэн нэг удаагийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд”* оршино. Ийнхүү богино хугацаанд *“гал унтраах”* байдлаар инфляцид хандсан нөхцөлд

*сангийн бодлогын хүрээнд зарим барааны нийлүүлэлтийг ихэсгэх, дотоодын зах зээл дээрх үнийг бууруулахад чиглүүлэн нийлүүлэгчид татаас олгох, гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, мөн хэрэглэгчдийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг зохицуулах, тухайлбал дээд үнэ тогтоох аргыг хэрэглэж болно. Мөнгөний бодлогын хүрээнд мөнгөний хатуу бодлого явуулах хувилбар байж болох юм. Гэхдээ эдгээр арга хэмжээ нь урт хугацаанд зах зээлийн эдийн засгийн голдрилыг эвдэх, далд эдийн засаг үүсэх, авилгал, хээл хахууль ихэсэх нөхцөл болох тул эдгээрээс аль болох зайлсхийх шаардлагатай.*

Богино хугацааны бодлого нь инфляцид хандсан хэсэгчилсэн бодлого байх агаад онцлог төрлийн, тухайлбал өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн, бензиний үнийн өсөлтийг хязгаарлахад чиглэгдэнэ. Төрөөс явуулах энэ талын бодлогын арга хэрэгслийг захиргааны болон зах зээлийн гэж ялгадаг бөгөөд зах зээлийн хэрэгслүүдийг ашиглах нь цаашид хор хохирол бага байх болно. Тухайлбал эрэлтийг хязгаарлах, нийлүүлэлтийг ихэсгэх гэх мэт арга хэрэгслүүд байх боломжтой.

## **7.2 ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО**

Дунд хугацааны бодлогын зорилго нь *“цаашид эдийн засгийн салбарын бүтцийг өөрчлөх, дотоод өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үндэс суурийг тавих, макро эдийн засгийн удирдлага зохион байгуулалтыг ил тод, тууштай болгох, техник, технологи, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд”* оршино. Дотоодын үйлдвэрлэгч нарт таатай нөхцөл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, техник технологийн шинэчлэлд туслах, гадаадын пүүс, компаниудыг татах маркетингийн хэрэгслүүдийг ашиглах боломжтой.

Дунд хугацаанд

- Төрийн институцын чадавхийг сайжруулах, үйл ажиллагааг ил тод болгох, бодлогын боловсруулалт, шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үйл ажиллагааг үр нөлөөтэй болгож, иргэдийн бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх
- Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, санхүүгийн эх үүсвэрүүдийг оновчтой хуваарилах
- Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлогыг өөрийн орны онцлог нөхцөлд нийцүүлэн боловсруулах, цаашид ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг давамгайл болгоход чиглүүлэх

- Импортыг орлох болон экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх, татварын оновчтой бодлогоор дэмжих
- Эрдэс түүхий эд, ноос, ноолуур, мах, сүү, арьс шир зэрэг уул уурхай, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах салбарт хүний нөөцийг бэлтгэж, сургах, нарийн технологи нэвтрүүлэхэд төрөөс дэмжин туслах
- Оюуны шингэц ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрлэлд хөрөнгө оруулах үндэсний болон үндэстэн дамнасан компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих
- Стратегийн зарим орд газруудыг гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ашиглаж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулах санхүүгийн чадамж хуримтлал бүрдүүлэх
- Малыг халдварт өвчнөөс хамгаалах, эрүүлжүүлэхэд орчин үеийн биотехнологийг нэвтрүүлэх
- Усалгаатай газар тариалангийн технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- Үр ашигтай фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс дэмжих
- Гаалийн тарифын бодлогыг үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа, бүтцийг бий болгох, өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, тэргүүний технологийг импортлох боломжийг бүрдүүлэхэд чиглүүлэх
- Инженерийн болон техник мэргэжлийн сургалтыг сайжруулах, нарийн мэргэжлийн монгол ажилтан, ажилчдыг сургах, дадлагажуулах
- Эдийн засгийн чөлөөт бүс, бусад хууль эрх зүйн тусгай зохицуулалтай бүсүүдийг байгуулах
- Санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, үндэсний хөрөнгө оруулагч нарын хөрөнгө босгох үйл ажиллагааг дэмжих
- Бараан бирж байгуулж, түүхий эдийн хангалтын гэрээг боловсронгуй болгосноор бараа, бүтээгдэхүүний үнэ тодорхой хугацаанд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх
- Дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, хот, хөдөөд үйлдвэрлэл эрхлэх ижил боломж, нөхцөлтэй болгох стратегиудыг хэрэглэх шаардлагатай юм.

### 7.3 УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГО

Урт хугацааны бодлогын зорилго нь *“Эдийн засгийн салбарын бүтцийг дундаж ба өндөр хөгжилтэй орны жишиг рүү дөхүүлэн, хараат байдлаас ангижрах, эдийн засаг, бизнесийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэн, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд”* оршино.

Урт хугацаанд

- Нарийн технологи бүхий, оюуны багтаамжтай, экспортын чиглэлтэй эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл давамгайлж, өрсөлдөөн хүчтэй болсны үндсэн дээр техник, технологийн шинэчлэл бүрэн хийгдэж хөдөлмөрийн бүтээмж дээшлэн, дэлхийн түвшинд өрсөлдөх
- Дэлхийн зах зээлээс хараат байдлаас ангижирч, аж үйлдвэрийн бренд бүтээгдэхүүнүүдтэй болох
- Эрчимжсэн ба уламжлалт мал аж ахуй хосолсон мал аж ахуйн салбартай болсноор дотоодын хүнсний хангамжийг шийдвэрлэх
- Газар тариалангийн тэргүүний технологийг нэвтрүүлэн, өөрийн орны хүнсний хэрэгцээг хангахуйц чадвартай болох
- Уул уурхай, газрын доорхи баялгийг зөв зохистойгоор ашиглан, өртөг их шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх
- Уламжлалт мал аж ахуйн байгалийн хараат байдлыг бууруулахад чиглэсэн цогц бодлогын үр дүнд тухайн аж ахуйг эрсдэлээс хамгаалах стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Үүний үр дүнд манай орны эдийн засаг байгаль болон дэлхийн зах зээлээс хараат байдлаас ангижрах төдийгүй, улирлын шинж чанартай үйлдвэрлэл бүхий тогтолцоог халж, тогтвортой үйл ажиллагаа бүхий тогтолцоог бүрдүүлэх юм.

## Хүснэгт 13. Инфляцийн эсрэг бодлогын хувилбар

Хугацаа	Зорилго	Зорилтууд	Бодлогын төрөл	Арга хэрэгсэл
Богино хугацаа	Тухайн үеийн нөхцөл байдлыг зөвөөр үнэлэн үнийн өсөлтөнд хариу үйлдэл хийхэд чиглэгдсэн нэг удаагийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг зогсоох</li> <li>Нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах</li> <li>Өргөн хэрэглээний бараануудын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх</li> </ul>	Сангийн бодлого	<ol style="list-style-type: none"> <li>Нийлүүлэгчид улсын төсвөөс татаас өгөх</li> <li>Гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх</li> <li>Дээд үнэ тогтоох</li> <li>Улсын нөөцийн сан байгуулах</li> <li>Төсөвт байгууллагын ажиллагсдын цалинг тогтвортой байлгах</li> <li>Нийгмийн чиглэлтэй үйл ажиллагаанд мөнгө бага зарцуулах</li> </ol>
			Мөнгөний бодлого	<ol style="list-style-type: none"> <li>Төв банкны үнэт цаасны хүүг өсгөх</li> <li>Нээлттэй зах зээлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх</li> <li>Заавал байлгах нөөцийн хувийг ихэсгэх</li> <li>Валютын ханшийг тогтвортой барих</li> </ol>

Хугацаа	Зорилго	Зорилтууд	Бодлогын төрөл	Арга хэрэгсэл
Дунд хугацаа	«цаашид эдийн засгийн салбарын бүтцийг өөрчлөх, дотоод өрсөлдөөнийг нэмэгдүүлэх үндэс суурийг тавих, макро эдийн засгийн удирдлага зохион байгуулалтыг ил тод, тууштай болгох, техник, технологи, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, санхүүгийн эх үүсвэрүүдийг оновчтой хуваарилах</li> <li>• Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлогыг өөрийн орны онцлог нөхцөлд нийцүүлэн боловсруулах, цаашид ДНБ-д аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийг давамгайл болгоход чиглүүлэх</li> <li>• Төрийн институцийн үйл ажиллагааг ил тод болгох, иргэдийн бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэх</li> <li>• Импортыг орлох болон экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрхлэх эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлэх, татварын оновчтой бодлогоор дэмжих</li> <li>• Эрдэс түүхий эд, ноос, ноолуур, мах, сүү, арьс шир зэрэг уул уурхай, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах салбарт хүний нөөцийг бэлтгэж, сургах, нарийн технологи нэвтрүүлэхэд төрөөс дэмжин туслах</li> <li>• Оюуны шингэц ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрлэлд хөрөнгө оруулах үндэсний болон үндэстэн дамнасан компаниудын хөрөнгө оруулалтыг дэмжих</li> <li>• Стратегийн зарим орд газруудыг гадаадын хөрөнгө оруулагч нартай хамтран ашиглаж, эдийн засгийн салбарын бүтцийг сайжруулах санхүүгийн чадамж хуримтлал бүрдүүлэх</li> <li>• Малыг халдварт өвчнөөс хамгаалах, эрүүлжүүлэхэд орчин үеийн биотехнологийг нэвтрүүлэх</li> <li>• Усалгаатай газар тариалангийн технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх</li> </ul>	Сангийн бодлого	<ol style="list-style-type: none"> <li>1. Татварын таатай нөхцөл бүрдүүлэх</li> <li>2. Олон Улсын зах зээлд үндэсний үйлдвэрлэгч гарах бизнес, эрх зүйн орчинг бүрдүүлэх</li> <li>3. Үндэсний үйлдвэрлэгч нарт техник, технологийн шинэчлэл хийх, худалдан авахад санхүүгийн тусламж үзүүлэх, эрх зүйн боломж нөхцөлөөр хангах</li> <li>4. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого боловсруулах</li> <li>5. Хөдөө хотыг холбосон түүхий эдийн нэгдсэн биржийн тогтолцоог бий болгох</li> <li>6. Нефть бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэр барих</li> <li>7. Мал аж ахуйн үржил селекцийн ажлыг эрчимжүүлэн зохион байгуулах</li> <li>8. Барааны бирж байгуулах</li> </ol>



Хугацаа	Зорилго	Зорилтууд	Бодлогын төрөл	Арга хэрэгсэл
Дунд хугацаа		<ul style="list-style-type: none"> <li>• Үр ашигтай фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд төрөөс дэмжих</li> <li>• Гаалийн тарифын бодлогыг үйлдвэрлэл, хэрэглээний зохистой харьцаа, бүтцийг бий болгох, өрсөлдөх чадвартай дотоодын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, тэргүүний технологийг импортлох боломжийг бүрдүүлэхэд чиглүүлэх</li> <li>• Инженерийн болон техник мэргэжлийн сургалтыг сайжруулах, нарийн мэргэжлийн монгол ажилтан, ажилчдыг сургах, дадлагажуулах</li> <li>• Эдийн засгийн чөлөөт бус, бусад хууль эрх зүйн тусгай зохицуулалтай бүсүүдийг байгуулах</li> <li>• Санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, үндэсний хөрөнгө оруулагч нарын хөрөнгө босгох үйл ажиллагааг дэмжих</li> <li>• Бараан бирж байгуулж, түүхий эдийн хангалтын гэрээг боловсронгуй болгосноор бараа, бүтээгдэхүүний үнэ тодорхой хугацаанд тогтвортой байх нөхцөлийг бүрдүүлэх</li> <li>• Дэд бүтцийн хөгжлийг сайжруулах, хот, хөдөөд үйлдвэрлэл эрхлэх ижил боломж, нөхцөлтэй болгох</li> </ul>	Мөнгөний бодлого	<ol style="list-style-type: none"> <li>1. Зээлийн хүүг бууруулах</li> <li>2. Урт хугацаатай хөнгөлөлтэй, хөгжлийн зээлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх</li> <li>3. Банкны салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлэх</li> </ol>

Хугацаа	Зорилго	Зорилтууд	Бодлогын төрөл	Арга хэрэгсэл
